

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2025 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2025 ОНЫ 06 ДУГААР САРЫН 02-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

*Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.*

БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2025 оны 06 дугаар сарын 02-ны өдөр, Даваа гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-5
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	6-40
1.Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй хууль, тогтоолын төслүүдийг чуулганаар хэлэлцүүлэх эсэх асуудал	6-8
2.Монгол Улсын Ерөнхий сайдад итгэл хүлээлгэх эсэх асуудал /“Монгол Улсын Ерөнхий сайдад итгэл хүлээлгэх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл/	8-40

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы
Төрийн байгуулалтын байнгын хорооны 06 дугаар сарын 02-ны өдөр
/Даваа гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Ж.Бат-Эрдэнэ ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 25 гишүүнээс 15 гишүүн хүрэлцэн ирж, 60.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 13 цаг 00 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Эмнэлгийн чөлөөтэй: Г.Уянгахишиг.

**Нэг.Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганаар
хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй хууль, тогтоолын төслүүдийг
чуулганаар хэлэлцүүлэх эсэх асуудал**

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Ц.Баянмөнх, Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын Байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, мөн албаны референт Б.Баярсайхан нар байлцав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7-д “Энэ хуулийн 5.1-д заасан жагсаалтад ороогүй хууль, тогтоолын төсөл өргөн мэдүүлснийг Зөвлөлийн саналыг харгалзан Төрийн байгуулалтын байнгын хороо хэлэлцэж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн бол чуулганаар хэлэлцүүлнэ.” гэж заасны дагуу өргөн мэдүүлсэн төсөл бүрээр санал хураалт явуулав.

Ж.Бат-Эрдэнэ: 1.Монгол Улсын Засгийн газраас 2025.05.01-ний өдөр өргөн мэдүүлсэн Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг иргэний журмаар нэхэмжлэх, нөхөн төлүүлэх тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	12
Татгалзсан:	3
Бүгд:	15

80.0 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Монгол Улсын Засгийн газраас 2025.05.27-ны өдөр өргөн мэдүүлсэн Төлбөрийн чадваргүйдлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 15
Татгалзсан: 1
Бүгд: 16
93.8 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Монгол Улсын Засгийн газраас 2025.05.27-ны өдөр өргөн мэдүүлсэн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тогтолцоо, шийдвэр гүйцэтгэгчийн эрх зүйн байдлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл, Эрүүгийн болон зөрчлийн хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн төсөл, Иргэний болон захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 17
Татгалзсан: 0
Бүгд: 17
100 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Монгол Улсын Засгийн газраас 2025.05.27-ны өдөр өргөн мэдүүлсэн Арилжааны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 18
Татгалзсан: 1
Бүгд: 19
94.7 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин нарын 20 гишүүнээс 2025.05.30-ны өдөр өргөн мэдүүлсэн Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 18
Татгалзсан: 2
Бүгд: 20
90.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Уг асуудлыг 13 цаг 05 минутад хэлэлцэж дууслаа.

Хоёр.Монгол Улсын Ерөнхий сайдад итгэл хүлээлгэх эсэх асуудал
/"Монгол Улсын Ерөнхий сайдад итгэл хүлээлгэх тухай" Улсын Их Хурлын тогтоолын төсөл/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Ц.Баянмөнх, Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын Байнгын

хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, мөн албаны референт Б.Баярсайхан нар байлцав.

“Монгол Улсын Ерөнхий сайдад итгэл хүлээлгэх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Номтойбаяр, Б.Баярбаатар, Ц.Сандаг-Очир, О.Номинчимэг, Б.Батбаатар, Ж.Баярмаа, Б.Энхбаяр, Э.Болормаа, О.Батнайрамдал нарын тавьсан асуултад Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ, Ёс зүй, дэгийн байнгын хорооны дарга Б.Баярбаатар, Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Ж.Бат-Эрдэнэ нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Н.Номтойбаяр, Ц.Сандаг-Очир, Б.Батбаатар, Ж.Баярмаа, Б.Пүрэвдорж, О.Батнайрамдал, П.Сайнзориг, Ж.Бат-Эрдэнэ нар үг хэлэв.

Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ Төрийн байгуулалтын байнгын хорооны гишүүний хувьд санал хураалтад оролцохгүйгээ мэдэгдэж, үг хэлсэн тул Байнгын хорооны хуралдааны ирцээс гаргав.

Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар Монгол Улсын Ерөнхий сайдад итгэл хүлээлгэх эсэх асуудлыг саналын хуудас ашиглаж, нууц санал хураалтаар шийдвэрлэе гэсэн горимын санал гаргав.

Ж.Бат-Эрдэнэ: Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатарын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 16
Татгалзсан: 7
Бүгд: 23

69.6 хувийн саналаар горимын санал дэмжигдсэн тул Монгол Улсын Ерөнхий сайдад итгэл хүлээлгэх эсэх асуудлыг саналын хуудас ашиглаж, нууц санал хураалтаар шийдвэрлэхээр тогтов.

Байнгын хорооны дарга Ж.Бат-Эрдэнэ “Тооллогын комисс байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Байнгын хорооны гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Ж.Бат-Эрдэнэ: “Тооллогын комисс байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 17
Татгалзсан: 6
Бүгд: 23

73.9 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Тооллогын комиссын даргаар Улсын Их Хурлын гишүүн Б.Батбаатар, Нарийн бичгийн даргаар Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар, гишүүнд Улсын Их Хурлын гишүүн Ж.Баярмаа нар ажиллахаар тогтов.

Тооллогын комисс 15 цаг 07 минутаас 15 цаг 13 минутад хуралдаж, нууц санал хураалт явуулах журам болон саналын хуудасны баталгаажуулсан загварыг тооллогын комиссын Нарийн бичгийн дарга, Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар танилцуулав.

Байнгын хорооны дарга Ж.Бат-Эрдэнэ “Нууц санал хураалт явуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Байнгын хорооны гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Ж.Бат-Эрдэнэ: “Нууц санал хураалт явуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 17

Татгалзсан: 6

Бүгд: 23

73.9 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

“Монгол Улсын Ерөнхий сайдад итгэл хүлээлгэх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн нууц санал хураалт 15 цаг 15 минутаас 15 цаг 33 минутад явагдаж, дүнгээ гаргаж дуусав.

Тооллогын комиссын Нарийн бичгийн дарга, Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар нууц санал хураалтад нийт 23 гишүүн оролцож, 17 гишүүн дэмжиж, 73.9 хувийн саналаар дэмжигдсэн болохыг танилцуулав.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Байнгын хорооны дарга Ж.Бат-Эрдэнэ Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 2 цаг 35 минут үргэлжилж, ирвэл зохих 25 гишүүнээс 24 гишүүн хүрэлцэн ирж, 96.0 хувийн ирцтэйгээр 15 цаг 35 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Ж.БАТ-ЭРДЭНЭ

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ
2025 оны 06 дугаар сарын 02-ны өдөр,
Дваа гараг Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар” танхим 13 цаг 00 минут

**ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

Ж.Бат-Эрдэнэ: Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая аа.

Ингээд Байнгын хороонд оролцож байгаа гишүүдийг танилцуулъя. Оюунсайханы Алтангэрэл гишүүн ирсэн байна. Баярмагнай Баярбаатар гишүүн ирсэн. Тогмидын Доржханд гишүүн ирсэн. Нямтайширын Номтойбаяр гишүүн ирсэн. Өлзийхүүгийн Шижир гишүүн ирсэн. Жадамбын Бат-Эрдэнэ ирсэн. Жудагийн Баярмаа гишүүн ирсэн. Сархадын Зулпхар гишүүн ирсэн. Цэндийн Сандаг-Очир гишүүн ирсэн. Батын Батбаатар гишүүн ирсэн. Энхбатын Болормаа гишүүн ирсэн. Одсүрэнгийн Номинчимэг гишүүн ирсэн. Цэвэгдоржийн Туваан гишүүн ирсэн. Ингээд ирц бүрдсэн тул Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэж ирсэн тул ТББХ-ны 2025 оны 6 дугаар сарын 2-ны өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье ээ.

Хэлэлцэх асуудлыг та бүхэнд танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй хуулийн төслүүдийг чуулганаар хэлэлцүүлэх эсэх асуудал.

2. Монгол Улсын Ерөнхий сайдад итгэл хүлээлгэх тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл Монгол Улсын Ерөнхий сайдын Л.Оюун-Эрдэнээс 2025 оны 5 дугаар сарын 28-ны өдөр ирүүлсэн тогтоолын төслийг хэлэлцэнэ ээ.

Хэлэлцэх асуудалтай холбоотойгоор асуух асуулттай гишүүд байна уу? Санал хэлэх гишүүд байна уу? Алга байна. Ингээд хэлэлцэх асуудалдаа орёе.

Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй хуулийн төслүүдийг чуулганаар хэлэлцүүлэх эсэхийг шийдвэрлэх тухай.

Ингээд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5.7-д энэ хуулийн 5.1-д заасан жагсаалтад ороогүй хууль тогтоолын төсөл өргөн мэдүүлснийг зөвлөлийн саналыг харгалзан Төрийн байгуулалтын байнгын хороо хэлэлцэж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул чуулганаар хэлэлцүүлнэ гэж заасан байгаа. Ингээд Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн төсөл бүрээр санал хураалт явуулна.

Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 5 сарын 1-ний өдөр өргөн мэдүүлсэн Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг иргэний журмаар нэхэмжлэх, нөхөн төлүүлэх тухай хууль, анхдагч хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5

дугаар зүйлийн 5.7 дахь хэсэгт заасны дагуу чуулганы хэлэлцүүлгийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтдаа бэлдье.

Санал хураалт.

15 гишүүнээс 12 гишүүн оролцож, 80 хувиар санал дэмжигдлээ.

2.Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 5 дугаар сарын 27-ны өдөр өргөн мэдүүлсэн Төлбөрийн чадваргүйдлийн тухай хууль шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7 дахь хэсэгт заасны дагуу чуулганаа хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт санал хураалтад 16 гишүүнээс 15 гишүүн оролцож 93.8 хувиар санал дэмжигдлээ.

3.Монгол Улсын Засгийн газар 2025 оны 5 дугаар сарын 27-ны өдөр өргөн мэдүүлсэн, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тогтолцоо, Шийдвэр гүйцэтгэгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл, Эрүүгийн болон Зөрчлийн хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн төсөл, Иргэний болон Захиргааны эрхийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7 дахь заасны дагуу чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтад 17 гишүүн оролцож, 17 гишүүн дэмжсэн байна. 100 хувиар санал дэмжигдлээ.

Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 5 дугаар сарын 27-ны өдөр өргөн мэдүүлсэн Арилжааны хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 5.7 дахь дахь хэсэгт заасны дагуу чуулганы хэлэлцүүлгийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

Санал хураалтад 19 гишүүнээс 18 гишүүн оролцож, 94.7 хувиар санал дэмжигдлээ.

5.Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин нарын 20 гишүүнээс 2025 оны 5 дугаар сарын 30-ны өдөр өргөн мэдүүлсэн Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5.7-д дахь хэсэгт заасны дагуу чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

Санал хураалтад 20 гишүүнээс 18 гишүүн оролцож, 90 хувиар санал дэмжигдлээ. Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй хуулийн төслүүдийг чуулганаар хэлэлцүүлэх эсэхийг шийдвэрлэх тухай асуудлыг хэлэлцэж шийдвэрлэлээ.

13.05 цаг

Хэлэлцэх асуудлынхаа 2-т орёё.

“Монгол Улсын Ерөнхий сайдад итгэл хүлээлгэх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл Монгол Улсын Ерөнхий сайд Оюун-Эрдэнээс 2025 оны 5 сарын 28-ны өдөр ирүүлсэн тогтоол.

Хуулийн тайлбарыг та бүхэнд танилцуулъя. Монгол Улсын Үндсэн хуулийн 44 дүгээр зүйлийн нэг дэх хэсэг, Ерөнхий сайд улсын төсвийн болон бодлогын тодорхой асуудлаар өөрт итгэл хүлээлгэх тогтоолын төслийг оруулбал Улсын Их Хурал 3 хоногийн дараа хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлнэ, 10 хоногийн дотор Улсын Их Хурлын нийт гишүүдийн олонхын саналаар шийдвэрлэнэ ээ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 102.2, Төрийн байгуулалтын байнгын хороо Ерөнхий сайдад итгэл хүлээлгэсэн тогтоолын төслийг хуралдаанаараа хэлэлцэн санал, дүгнэлт гаргаж нэгдсэн хуралдаанд оруулна гэж заасан байгаа.

Ингээд “Монгол Улсын Ерөнхий сайдад итгэл хүлээлгэх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн танилцуулгыг Монгол Улсын Ерөнхий сайд Улсын Их Хурлын гишүүн Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэ хийнэ ээ.

Оюун-Эрдэнэ сайдын микрофоныг нээе.

Л.Оюун-Эрдэнэ: Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Та бид хамтдаа 2024 оны ээлжит сонгуулийг 126 гишүүнтэй бүсчилж томсгосон тойрогтой холимог тогтолцоотой. Ийм шинэ парламентын анхны сонгуулийг хийсэн. Сонгогчдын саналыг гээхгүй байх ийм зарчмыг бид нар үндэслэж аль болохоор зөвшилцлийн, аль болохоор парламентын засаглал төгөлдөржих энэ агуулга дээр улс төрийн намууд зөвшилцөж Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг хийсэн. Энэ үр дүнг бид нар эрхэмлэж Үндсэн хуулийг хийсэн 3 нам хамтарч, хамтарсан Засгийн газар байгуулах нь зүйтэй гэж үзсэн. Яагаад гэвэл улс орны өмнө тулгамдсан сорилтууд байна. Өмнө нь гацчихсан байсан том том төслүүд байна. Үүн дээр хэдүүлээ зориг гаргаад шийдэл гаргая гэдэг ийм агуулгаар. Тухайн үед мэдээж энэ нөгөө шүүмжлэлтэй олон асуудлууд байсан. олонхыг авсан МАН яагаад дангаараа Засгийн газар байгуулахгүй заавал хамтрах ёстой юм бэ гэдэг зэрэг олон асуудлууд үүсэж байсан. Миний хувьд хамтарсан Засгийн газрын энэ платформ өөрөө энэ Үндсэн хуулийн платформ.

Тийм учраас Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг хийх энэ өдрөө бид нар ер нь хамтарч засаглах нь зүйтэй юм гэдэг энэ ерөнхий зарчмыг гаргасан гэдэг байдлаар тайлбар хийж ингээд хурдтай хөгжлийн төлөөх зориг хэмээх уриатайгаар гэрээ байгуулж, хамтарсан Засгийн газар байгуулагдсан.

Ингээд 10 сарын хугацаа өнгөрч байна. 10 сарын хугацаанд бид нар хөгжлийн 14 мега төслийг зарлаж олон жил гацсан Эрдэнэбүрэн, Гашуун сухайт, Ганцмод, Орано, мөн эрчим хүчний суурь реформ, нийслэл дээр ч гэсэн дэд бүтцийн томоохон асуудлуудыг шийдвэрлэх мөн бүсчилсэн хөгжлийн зорилтын хүрээнд томоохон зорилтуудыг дэвшүүлэх зэрэг ийм томоохон бодлогын үр дүн энэ 10 сарын дотор гарсан нь бодитой. Би үүн дээр одоо Засгийн газарт хамтран ажиллаж байгаа журмын нөхдөдөө мөн АН, ХҮН намын удирдлагуудад талархал илэрхийлэх нь зүйтэй. Цаг хугацаа өнгөрнө. Энэ нь өөрөө Монгол Улсын хувьд бол түүх болж үлдэнэ ээ.

Мэдээж Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт туссан зорилтууд ялангуяа Үндэсний баялгийн сан зэрэг ийм томоохон асуудлуудыг явуулахад асуудлууд үүссэн тодорхой хэмжээнд. Ингээд сүүлийн өдрүүдийн үйл явдлууд бол өрнөсөн. Би өнөөдөр чуулган дээр ч гэсэн нээлттэй үг хэлнэ.

Их Хурлын гишүүд та бүхнийг ч гэсэн нээлттэй, чөлөөтэй асуулт санал тавиасай гэж хүсэж байгаа юм. Яагаад гэвэл энэ бол нэлээн ийм идеологийн зөрүүтэй хамтарсан Засгийн газрын цаашдын хувь заяатай холбоотой ер нь Монгол Улс цаашид хамтарсан Засгийн газар явах уу, үгүй юу, нийгмийн тулгамдсан сорилтуудаа шийдвэрлэж чадах уу үгүй юу зэрэг ийм олон шалтгаант үр дагавруудыг дагуулж байгаа ийм томоохон шийдэл болно.

Яагаад гэвэл энэ бол 126-тай бид бүгдийн шинэчилсэн парламентын бүрдүүлсэн анхны Засгийн газар.

Тийм учраас үүн дээр би туйлын хариуцлагатай хандаж олон асуулт, санал олон нийтийн дунд байгаа эргэлзээ, Монгол Улс цаашид ямар хөгжлийн замаар замнах уу тогтвортой засаглалыг бид нар ер нь хэрхэн хадгалж үлдэж чадах уу үгүй юу гэдэг ийм нээлттэй мэтгэлцээн болоосой гэж бодож Монгол Улсын Үндсэн хуулийн 44 дүгээр зүйлийн нэг дэх хэсэгт заасны дагуу Засгийн газраас дэвшүүлэн тавьж байгаа хамтарсан Засгийн газрын гэрээнд дэвшүүлэн тавьсан асуултуудад сорилт учирч байгаа учраас би одоо өөрийн бүрэн эрхэд байгаа энэхүү асуудлыг хөндөх нь зүйтэй гэж үзсэн юм аа.

Тийм учраас би өнөөдөр бүх асуултад илэн далангүй чин сэтгэлээсээ хариулахад бэлэн байна. Парламентын гишүүд та бүхэн бол ард түмнээс сонгогдсон элч, нийт улсын ашиг сонирхлын төлөө ажиллах тангараг өргөсөн хүмүүс.

Тийм ч учраас парламентын мэтгэлцээнээр дамжуулж олон нийт, Монголын ард түмэн, энэ асуудал дээр томоохон дүгнэлт, цааш цаашдын сургамж байх нь, цаашдын ажиллах Засгийн газар, ялангуяа 126-тай бүрдэж байгаа энэ зөвшилцөөний 5 намтай энэхүү шинэ парламентад тийм шинэ жишиг болж үлдэх нь туйлын чухал юм гэж миний хувьд үзэж байгаа.

Тийм учраас өөрт байгаа энэхүү эрхээ эдэлж Ерөнхий сайдад итгэл үзүүлэх эсэх тухай энэ асуудлыг нээлттэй ярилцах нь зүйтэй гэж үзсэн. Ингээд би “Ерөнхий сайдад итгэл хүлээлгэх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Улсын Их Хуралд хүргүүлсэн байгаа. Тэгээд өнөөдөр ТББХ-оор хэлэлцэж байна. Мэдээж илэрхийлэх, тайлбарлах үг байгаа. Үүнийг давхцуулахгүйгээр нэгдсэн чуулган дээр

илүү дэлгэрэнгүй ярьчих нь зүйтэй байх гэж бодож байна. Ингээд анхаарал тавьсан та бүхэнд баярлалаа.

Ж.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Хэлэлцэж байгаа асуудалтай холбоотойгоор асуух асуулттай гишүүд байвал нэрсээ өгнө үү? Пүрэвдорж гишүүнээр тасаллаа. Номтойбаяр гишүүн.

Н.Номтойбаяр: Ямартаа ч Ерөнхий сайд ер нь хэн ч бай Үндсэн хуулийн 44.1-д заасан итгэл үзүүлэх эсэх асуудлыг оруулж ирж байгаа нь ер нь цаашдаа шинэ жишиг болж, шинэ сахилга бат ёс зүй болж хэвшвэл болно гэдэгт итгэж байна. Энэ мартагдсан Үндсэн хуулийн заалтыг амь оруулж байгаа Ерөнхий сайд Оюун-Эрдэнэд ямар ч байсан талархал илэрхийлье. Надад нэг л асуулт байна. Итгэл үзүүлэх тухай албан бичигтэй хууль зүйн хувьд ч тэр, бусад улс төрийн нөхцөл байдлуудын хувьд ч тэр маш анхааралтай үг үсэггүй нягталж нэлээн шалгалаа.

Мэдээж энэ албан бичгийг боловсруулахдаа үгийн сонголт, утга найруулга, улс төрийн мессеж бүх зүйлийг л олон талаас нь харж үзсэн байж таараа. Тэгээд энэ албан бичиг дээр ингэж бичсэн байгаа юм. Үүссэн улс төрийн нөхцөл байдлаас шалтгаалан цаашид сонгодог парламентын тогтолцоог төгөлдөршүүлэх дэмжлэг шаардлагатай байна гээд. Энэ үг өгүүлбэрийн цаад учир шалтгаан юу юм бэ? Яагаад ингэж бичих болов? Ямар улс төрийн нөхцөл байдал үүсэв? Энэ нь ямар шалтгаан болов? Яагаад сонгодог парламентын тогтолцоог төгөлдөршүүлэх шаардлагатай юм байна гэж та үзэв ээ? Энэ дээрээ хариултаа авъя.

Дээрээс нь ташрамд нэг зар дамжуулах юм уу яах юм хэвлэл мэдээллийн байгууллагууд Ерөнхий сайдад уламжлаад өгөөч ээ, бидэнтэй ил тод, нээлттэй уулзаач гэж хүргүүлснийг танд уламжилъя.

Ж.Бат-Эрдэнэ: Оюун-Эрдэнэ сайд хариулъя.

Л.Оюун-Эрдэнэ: Хэвлэл мэдээллийнхэндээ хандаад би ямар ч үр дүн гарснаас үл хамааран нээлттэй энэ үйл явдлын дараа хэвлэлийн бага хурал хийх боломжтой. Яагаад парламентаар эхэлж ярих ёстой вэ гэж үзсэн бэ гэхээр парламентын процесс буюу ард түмний эрхэм элч төлөөллийн төв байгууллага дээр эхэлж асуултад хариулах нь зүй ёсны асуудал. Энэ сонгодог парламентад байдаг нийтлэг жишиг. Тэрний өмнө жишээлбэл тайлбар хийгээд ямарваа нэгэн байдлаар нөлөө үзүүлэх гээд өөрийгөө зөвтгөх гээд эсвэл асуудлыг нэг талд нь гарч тайлбарлах гээд байх ийм сонирхол надад бол огт байгаагүй гэдгийг бас хэвлэл мэдээллийнхэндээ хандаж хэлье.

Тэгээд миний хувьд хэвлэлийнхэнтэйгээ нээлттэй л уулздаг. Яг тэр жишгээрээ та бүхэн маань уулзаад сонирхсон бүхий л асуултдаа хариулаарай. Гагцхүү парламентын процесс эхэлж явах нь зүйтэй юм гэж үзсэн. Өнгөрсөн 7 хоногийн 5 дахид уг нь хийчих нь зүйтэй гэдэг ийм бодолтой байсан. Гэхдээ парламентын зохион байгуулалтын процесс болж өгсөнгүй. Хуулийн хугацаатай байсан гэдгийг манай хэвлэл мэдээллийнхэн маань ойлгоосой гэж хүсэж байна.

Сонгодог парламентын засаглал гэдэг энэ агуулгыг бид бүгдээрээ л мэдэж байгаа. Монгол Улс бол одоо парламентын засаглалтай. Сая бид нар хэллээ. Төлөөллөө илүү том болгосон. Энэ нь юу гэсэн үг вэ гэхээр парламент өөрөө бие даан шийдвэр гаргадаг байх энэ эрхийг л баталгаажуулж байгаа юм. 76-аас 126

болсноороо, олон экспертүүд орж ирснээрээ санал гээгдэхгүй жагсаалтыг төлөөлж байгаа гишүүд томсгосон тойргоос нэлээн өндөр чансаатай сонгогдож байгаа парламентын гишүүд бүгдээрээ бид нар Монгол Улсын ард түмнийг төлөөлж байгаа юм.

Тийм учраас ард түмнийг төлөөлж байгаа элчийн хувьд энэ шийдвэрээ л бидний хувьд гаргах нь зүйтэй. Энэ ч агуулгаараа би сонгодог парламентад байдаг нийтлэг жишгийг хэвшүүлэх гэж л өнөөдрийн энэ итгэл үзүүлэх эсэх тухай энэ асуудлыг оруулж ирж байгаа юм. Тэгээд сонгодог парламенттай холбоотой олон л асуудлыг ярьж болно. Тэгээд өнөөдөржингөө л бид нар энэ асуудалтай холбоотой олон зүйл дээр би зарчмын байр суурь илэрхийлэх байх. Тэгээд Номтойбаяр гишүүн яг дэлгэрэнгүй детальчилсан асуулт асуувал би хариулахад бэлэн байна.

Энэ бүх мэтгэлцээн өөрөө сонгодог парламентын соёл. Парламент өөрөө засгийн газраа бүрдүүлж өөрөө огцруулдаг байх нь үндсэн хуулийн зарчим. Үүнд хэн ч ямар нэгэн байдлаар нөлөөлөхгүй байх учиртай. Энэ ард түмний олгогдсон парламентын онцгой бүрэн эрхийн асуудал. Тийм учраас олон талаас парламент шүүн хэлэлцээд парламентаар дамжуулж, олон нийт, ард иргэдийн эргэлзээ болон асуудлуудыг тайлаад, нийгмийн дүгнэлтийг ч, парламентын олонхыг ч нэг талд байх энэ л шийдвэр Монгол төрийн шийдвэр. Энэ агуулгаар энэ асуудлыг оруулж ирсэн гэдэг зүйлийг хэлье.

Ж.Бат-Эрдэнэ: Баярбаатар гишүүн асуултаа асууя.

Б.Баярбаатар: Асуулт гэхээсээ илүү саналаа хэлчихсэн нь зөв байх аа. Ерөнхий сайдад итгэл хүлээлгэхийг дэмжиж байгаа. Өнөөдөр яг энэ албан ёсоор энэ хуулийн дагуу Үндсэн хуулиар олгогдсон эрхээ гүйцэтгэх засаглалын тэргүүн ч, парламент ч өнөөдөр яг хэрэгжүүлж энэ цаг мөчөөс эхэлж байна. Түүхэндээ анх удаа энэ итгэл үзүүлэх тогтоол орж ирж байгаа юм байна лээ. Энэ нэг талаараа соёл гэж харж байгаа. Би Номтойбаяр гишүүний гаргасан саналтай адил байгаа. Өнөөдөр өглөө МАН-ын бүлэг хуралдсан. Бүлэг дээр ямар нэгэн хайрцагласан шийдвэрийг гаргаагүй. Өнгөрсөн 7 хоногт МАН-ын Бага хурал хуралдсан. Тэрэн дээр Ерөнхий сайдыг огцруулах эсэх асуудлыг яриагүй. Шийдвэр ч гараагүй. Энэ бол цэвэр эрх зүйт төрийн зарчмаараа парламентын эрх үүрэг. Тэгээд энэ үүрэг яг энэ цаг мөчөөс л эхэлж хэрэгжиж эхэлж байгаа шүү. Сая энэ Төрийн байгуулалтын байнгын хорооны хурал нээгдсэнээр.

Тэгэхээр одоо энэ парламент өөрөө эрхээ эдлэх ёстой. Ерөнхий сайдын Үндсэн хуулиар олгогдсон энэ парламенттай хандсан хандлага. Өнөөдөр бид нар энэ гүйцэтгэх засаглал түүний тэргүүнийг парламент томилно, буцаагаад парламент л чөлөөлнө. Хариуцлагын асуудал парламент дээр л хамаатай. Өнөөдөр бид нар парламентын засаглалтай улс гэдгээ өнгөрсөн хугацаанд ч, өнөөдөр ч, цаашдаа ч бид нар энийг төлөвшүүлэх шатан дээр илүү анхаарах ёстой гэж үзэж байгаа юм. Тэгж байж энэ хяналт энэ харилцан энэ эрх мэдлийн хуваарилалт чинь өөрөө тэнцвэржих юм аа. Энэ байр сууриас хандаж байгаа учраас би Төрийн байгуулалтын байнгын хорооныхоо гишүүний зүгээс Ерөнхий сайдад итгэл үзүүлэхийг дэмжиж байгаа гэдэг байр сууриа илэрхийлж байна аа.

Надад асуулт алга. Баярлалаа.

Ж.Бат-Эрдэнэ: Үг хэллээ. Дараагийн гишүүн Сандаг-Очир гишүүн асуултаа асууна.

Ц.Сандаг-Очир: Байнгын хорооны дарга энэ асуулт, үг цугтаа юу тусдаа юу?

Ж.Бат-Эрдэнэ: Тус тусдаа, дараа нь үг байгаа шүү.

Ц.Сандаг-Очир: Тэгвэл би Ерөнхий сайдын оруулж ирж байгаа итгэл үзүүлэх эсэх асуудлаар ингээд санал хураалт явах юм шиг байна. Тэгээд энэ санал хураалт хэр ач холбогдолтой юм бэ? Энэ Байнгын хорооны санал, дүгнэлтээр чуулганы нэгдсэн хуралдаанд санал хураалт явахгүй юм байна шүү дээ. Дэгийн тухай хуулиараа дэгийн тухай хуулийн тэр 103-аар чинь. Уг нь бол одоо Байнгын хороогоор орж ирсэн асуудал болгоныг тухайн Байнгын хороо хэлэлцээд Байнгын хорооны санал, дүгнэлтээр дэмжсэн, дэмжээгүйгээр нь үндэслээд дүгнэлт гараад тэр дүгнэлтийг үндэслээд чуулганы нэгдсэн хуралдаанд асуудал хэлэлцэгдэх.

Гэтэл яг энэ дэгийн бай хуулиар чинь бол энэ Байнгын хорооны санал, дүгнэлт одоо тэгээд санал хураалт шийдвэр яаж гарахаас хамаараад энэ санал хураалт ямар ч ач холбогдолгүй харагдаж байгаа. Энэ дэгийн тухай хуулиараа одоо бол ямар ч ач холбогдолгүй.

Тэгэхээр одоо энэ Байнгын хорооны гишүүдийг одоо ингээд л санал хураалт явуулаад л тэгээд л ил, нууцаар гээд л ингээд л бөөн асуудал болоод л ингээд л нэг 2, 3 хуваагаад ингэж байсан дор бол санал хураах шаардлага байхгүй, ач холбогдол байхгүй.

Хуулиараа тийм байгаа учраас шууд нэгдсэн чуулган дээрээ санал хураалтаа дэмжих эсэхээ шийдээд явбал яасан юм бэ гэдэг ийм нэг санал гаргаж байна. Тэгээд бид нар одоо энд ямар ч шийдвэр дэмжсэн дэмжээгүй шийдвэр гараад гээд Байнгын хорооны санал, дүгнэлт тэнд уншигдахгүй юм байна шүү дээ. Зүгээр л Байнгын хорооны дарга бол Төрийн байгуулалтын байнгын хороо хэлэлцлээ. Ийм шийдвэр гарсан байна л гэж уншина уу гэхээс биш Байнгын хорооны саналыг үндэслээд ийм дүгнэлт байхгүй юм байна. Энэ дээр Байнгын хорооны дарга юм уу, Байнгын хорооны зөвлөх юмнууд бас нэг асуултад хариулж өгөөч, тодруулж өгөөч.

Бид нар одоо санал хураалт, нууцаар илээр явууллаа гээд ач холбогдол байна уу үгүй юу гэдгийг нэг тодруулж өгөөч.

Ж.Бат-Эрдэнэ: Энэ зайлшгүй нэг ярих асуудал байгаад байгаа юм аа. Энэ Баярбаатар гишүүн, Ёс зүй дэгийн байнгын хорооны дарга энэ дээр нэг тайлбар хэлээдхээч.

Б.Баярбаатар: Сандаг-Очир гишүүний асуултад хариулъя.

Тэгээд энэ яг хууль зүйн талаасаа энэ дэгийн тухай хуулийн 102.1-д бол Ерөнхий сайдад итгэл хүлээлгэх тогтоолоо Улсын Их Хуралд оруулна гэж байгаа юм. 102.2 дээр холбогдох Байнгын хороо, Төрийн байгуулалтын байнгын хороо Ерөнхий сайдад итгэл хүлээлгэх тогтоолын төслийг хуралдаанаараа хэлэлцэнэ. Одоо бид нар яг хэлэлцэж байна. Санал, дүгнэлт гаргаж нэгдсэн хуралдаанд оруулна гэж байгаа юм. Санал, дүгнэлт гаргана гэдэг маань санал хураана гэсэн үг.

Тэгээд дүгнэлтээ бид нар нэгдсэн хуралдаанд оруулна гэж байгаа байхгүй юу. Танилцуулна биш оруулна гэж байгаа юм, оруулна. Гэтэл яг 102.3 дээрээ энэ хуулийн 102.1-д заасан тогтоолын төслийг гэдэг маань нөгөө Их Хуралд оруулсан тогтоолын төслийг тэгэхээр нөгөө 102.2, 102.3 хоёр чинь өөрөө зөрчилдөөд ирж байгаа юм, яг энэ дэгийн хуулиараа болохоор.

Тэгэхээрээ бид энэ 102.3-аа бариад Их Хурлаар хэлэлцэх нь зүйтэй гэсэн ийм Дэгийн байнгын хорооны талаасаа ийм санал байгаа. Тэгэхдээ өнөөдөр Төрийн байгуулалтын байнгын хороо Их Хурлын бүтцийн байгууллага. Их Хуралд би түрүүн хэлсэн, санал дээрээ.

Их Хурал яг албан ёсоор хэлэлцэж эхэллээ гэдэг маань энэ байж байгаа. Тэгээд яг санал хураахгүй гээд яачихаар сүүлд нь бид нар энэ 102.2-оо бас зөрчих магадлал байгаад байгаа юм. Санал, дүгнэлт гэдэг үгэн дээрээ бид нар очоод зөрчихнө. Нэгдсэн чуулганд бол энэ дүгнэлт танилцуулагдана шүү.

Ж.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Энэ бүүр ч зөрчилдөх асуудал ч гайгүй харагдаж байгаа юм. Зүгээр 102.3 дээр энэ хуулийн таны хэлсэнчлэн 202.1-д заасан тогтоолын төслийг гэж байгаа шүү дээ. Тогтоолын төслийг өөрөөр хэлбэл 102.1-д чинь Монгол Улсын Ерөнхий сайд Үндсэн хуулийн 44 дүгээр зүйлд заасны дагуу өөрт нь итгэл хүлээлгэх тогтоолын төслийг оруулж ирэх ёстой. Өөрт нь итгэл хүлээлгэх тогтоолын төсөл. Тэгэхээр 103 дээрээ болохоор 3.2 дээр болохоор энэ 102.1-д заасан буюу өөрт нь итгэл үзүүлэх тогтоолын төслийг Улсын Их Хурлын нийт гишүүдийн олонхын саналаар баталсан гэж байгаа юм. Өөрөөр хэлбэл Байнгын хорооны санал биш энэ тогтоолын төслийг шууд чуулган дээр хэлэлцэхээр болж байгаа байхгүй юу даа. Тэгээд хэдүүлээ энийг хэлэлцлээ.

Номинчимэг гишүүн.

М.Номинчимэг: Бүгдээрэнд нь энэ өдрийн мэндийг хүргэе. Би энд бол илүү олон нийтээс хамгийн их мэдмээр байгаа асуугаасай гэж бодож байгаа иргэдээс ч гэсэн ирж байгаа энэ санал дээр үндэслээд нэг асуулт Ерөнхий сайдаас асууя гэж бодож байна.

Энэ өнөөдрийг хүртэл энд орж ирж байгаа асуудал юунаас эхлэлтэй вэ гэхээр 3 орчим 7 хоногийн өмнө Ерөнхий сайдын хүүгийн асуудал дэгдээд орлогоо нотлооч гэдэг хөдөлгөөн өрнөсөн. Төд удалгүй энэ нь огцрох амархан гэдэг хөдөлгөөн болсон. Тэгээд нэг их удалгүй энэ маань МАН-ын Бага хурлын хамтарсан засагтай байх уу үгүй юу гэдэг шийдвэр руу орсон. Тэгээд өнөөдөр бид нар Улсын Их Хурал дээр Ерөнхий сайдад бодлогын асуудлаар итгэл хүлээлгэх үү үгүй юу гэдэг асуудал болоод орж байна. Энэ гурван 7 хоногийн хугацаанд орлогоо нотлох асуудал маань бодлогын асуудал дээр итгэл хүлээлгэх асуудал болоод хувирчихсанд үнэндээ иргэд ч, нийгэмд ч, яагаад ийм болчхов гэдэг үнэлэлт дүгнэлтийг өгөх боломж олдсонгүй. Бидний хувьд ч гэсэн юу болоод байна гэдгийг тунгаан бодох боломж хомс байлаа гэж харж байна.

Тэгэхээр одоо гадаа жагсаж байгаа олон хоног энд жагсаж байгаа залуучуудыг ойлгож байна, сайшааж байна, үзэл бодлоо илэрхийлж байна. Энэ бол ардчилсан нийгмийн эрүүл үзэгдэл гэж харж байгаа. Гэхдээ сошиал дээр гарахад, сошиал дээр бие биеийгээ харлуулдаг пи ар гүтгэж, гүжирдэж байгаа асуудал бол хэрээс хэтэрч байна.

Өчигдрөөс эхлээд Улсын Их Хурлын гишүүд рүү ч гэсэн ингээд зохион байгуулалттай зуу зуун мессежүүд ирж байна аа. Над руу ч гэсэн ирж байна. Яг өнөөдөр санал хураалтад нөлөөлөх зорилготой ийм нэг шантаажилсан, эсвэл айлгасан тиймээ. Ийм хэн нь мэдэгдэхгүй зохион байгуулалттай яг адилхан мессежүүд ирж байна. Тэгээд бид нар төрийн шийдвэр бол ул суурьтай шүүн бодож байж гаргах ёстой гэж бодож байгаа. Энэ хөөсөрсөн суртал ухуулгынхаа дотор талцуулсан ийм нийгмийг талцуулсан хар пи ар их болж байна. Сарниулсан ийм элдэв дуулиануудаас үнэхээр олон нийт залхаж байна. Бид ч залхаж байна. Тэгээд энэ дээр олон нийт ард түмэн юу хүсэж байна гэхээр эрүүлээр тунгаан бодох энэ орон зайг өгөөч ээ, цаг хугацааг өгөөч ээ.

Дан ялангуяа Ерөнхий сайдаас хувь улс төрчийн хувьд энэ дээр улс төрчийн манлайг үзүүлээч гэдэг юмыг л хүсээд байна. Тэгэхээр нөгөө анхнаасаа орлогоо нотлох асуудал маань яаж явж байгаад ийм асуудал болоод хувирчав? Энэ орлогоо нотлох асуудал ер нь ямар шатад байна? Үүнийг Ерөнхий сайд бас олон нийтдээ ард түмэндээ ил тодоор тайлбарлаасай гэж хүсэж байна.

Тэгэхээр энэ талаар Ерөнхий сайд дэлгэрэнгүй тайлбар өгөөч гэж хүсэж байна.

Ж.Бат-Эрдэнэ: Оюун-Эрдэнэ сайд хариулъя.

Л.Оюун-Эрдэнэ: Та бүхэн бүгдээрээ л ажигласан байх. 5 сарын 14-нд Гашуунсухайт-Ганц модны төмөр замын хил холболт болсон. Туваан сайд, Сангийн сайд гээд бид нар олуулаа ингээд явсан. Гантөмөр дарга Доржханд сайд нар ч явж байсан. Яг тэр үетэй давхцаад ийм мэдээлэл цацагдсан. Би хүрч ирээд тайлбар өгөөд тэр өдрөө л АТГ-т бүх материалуудаа бүрдүүлээд өгчихсөн. Тэгээд ялангуяа гишүүдийн хувьд та бүхэн бүгдээрээ л мэдэж байгаа. Бид нар бүгдээрээ л хөрөнгө орлогынхоо мэдүүлгийг өгдөг. Хөрөнгө орлогынхоо мэдүүлэг дээр үндэслээд бид нар орлогоо нотлох ёстой. Тэгээд бүх материалуудаа аваад ингээд өгчихсөн. Ингээд хүүтэйгээ уулзсан. Хүүтэйгээ уулзаад юу болов оо гээд ингээд асуусан. Тэгээд манай хүү очиж тайлбар өгсөн байгаа. Хүү маань бол 23 настай. Тэгээд уулзаад ярихад бол яалт ч үгүй нэгэн бүсгүйд хайр сэтгэлтэй болсон нь үнэн байна.

Тэгээд бие давхар болоод ингээд бөгж бэлэглэсэн л юм билээ. Бөгж нь 17 сая төгрөгийн үнэтэй бугуйвч бэлэглэсэн тэр нь 500 мянган төгрөгийн үнэтэй. Авсан дэлгүүр бүх л тэр нөгөө материалуудыг нь АТГ бүгдийг нь л өгсөн байгаа. Тэр нэг том үнэтэй машин тэрийг би судалж үзсэн. Монголд ерөөсөө 10 хүрэхгүй л байдаг юм байна лээ. Тэр бүгд худлаа мэдээлэл.

Тийм учраас энэ бүх зүйлүүд ХОМ опен дата дээр нээлттэй байж байгаа, АТГ-ын цахим мэдээлэл дээр байж байгаа. Ингээд АТГ аваачаад өгчихсөн. Хугацааны хувьд бол үүнийг ХОМ-тээ нягтлаад энэ бүх зүйлүүд яасан бэ гэдгийг нь нягтлаад тэгээд буцаагаад хариу өгөх юм. Энэ 30-аас 60 хоног байдаг. Тэгээд нэгэнтээ аваачаад өгчихсөн. Одоо тэгээд тэртээ тэргүй Улсын Их Хурал дээр яригдах ийм зүйл дээр, хэвлэл мэдээлэлд одоо жишээлбэл ингээд хөндлөнгөөс би тайлбарлаад ингээд байх нь нэг тийм зохимжгүй ч юм шиг л тийм мэдрэмж төрсөн.

Тэгэхээр өнөөдөр бүх л асуултыг та бүхэн асууж болно. Үүгээр дамжаад ингээд олон нийтэд хангалттай тайлбарлахад миний хувьд бэлэн байна. 23 настай

хүүхэд мэдээж би хүүтэйгээ уулзаж цаг гаргаж чадахгүй. Миний аав хүний хувьд алдаа. Би энийг ойлгож байгаа. Гэхдээ 23 настай залуу гэдэг бол бие даасан ийм эрх зүйн чадамжтай л иргэн шүү дээ. Би 23 настай байхдаа Дэлхийн зөн ОУБ-д салбар удирдаад л явж байсан. Тэр хүн одоо хэнд хайр сэтгэлтэй болох яаж амьдралын амьдралаа зохиохыг би ингээд хөндлөнгөөс оролцоод байх нь зохисгүй. Мэдээж олон нийтийн зүгээс зөв амьдраасай аль болохоор янз бүрийн юманд чи ингээд нэг холбогдчихгүйхэн шиг хэл ам битгий татлаасай гэдэг ийм агуулгаар би 2 хүүдээ хоёуланд нь л дандаа хэлдэг. Харин бүүр ингэж нөгөө нэг бас нэг ийм олон нийтийн өмнө гаргахгүй ингэж явж байгаад энэ нь нэг тийм нэрмээс болчхов уу ч гэж би зүгээр өөртөө асуулт тавьсан тийм зүйл байгаа шүү гэдгийг хэлье.

Миний ХОМ ойлгомжтой доо. Хүлэг контент, Херо энтертайнментын 50 хувь л байдаг. 2017 оноос хойш энэ дандаа л тогтвортой байж байгаа. Энэ бүгдээрээ л open data энэ тэрд ингээд байж байгаа зүйл.

Манай хүүгийн хувьд багаасаа л жишээлбэл нэг тийм зураг эд нар авах сонирхолтой тийм л хүүхэд. Та нар ч бараг зарим нь бүгдээрээ мэднэ. Тэгээд сонирхлынхоо.../минут дуусав/.

Ж.Бат-Эрдэнэ: Оюун-Эрдэнэ сайдын микрофоныг нэмж өгье.

Л.Оюун-Эрдэнэ: Сонирхлынхоо дагуу л тийм контент энэ тэр хийх л ийм дуртай хүүхэд. Манай аав зураач хүн. Надад бол нэг их тийм зургийн авьяас байхгүй. Харин манай хүүд яг тийм авьяас байдаг. Тэрнийхээ л дагуу ингээд энд тэнд контент хийгээд ингээд явдаг л ийм л залуу. Цаашдаа ч энэ ажлаа хийгээд л өөрийнхөө л амьдралаар явах байх тийм зүйл шүү гэдгийг хэлье.

Тэгээд яах вэ мэдээж энэ зүйлтэй холбоотой бүх зүйл хугацаандаа нотлогдоно гэдэгт итгэлтэй байгаа. Миний хувьд ХОМ болон өөрийнхөө орлогод хэрвээ эргэлзэж байсан бол ийм олон галтай янз бүрийн сэдэв рүү орохгүй байсан байх. Залуучуудтай би хэрвээ зөвхөн энэ жагсаалын орлого нотлох асуудал байсан бол би шууд гараад л уулзчихна. Өмнө нь ч би 2, 3 жагсаал дээр гараад л уулзчихаж байсан та бүхэн бүгдээрээ мэдэж байгаа. Энэ цаг нь дуусаж байх шиг байна.

Ж.Бат-Эрдэнэ: Тодруулах юм уу? Номинчимэг гишүүн тодруулъя.

О.Номинчимэг: Саяын асуултад нэлээн тайлбар өгч байх зуур хугацаа нь дуусчихлаа. Тэгэхээр гүйцээж хариулах маягаар асуултдаа нэмэлт хариултыг нь авъя.

Ж.Бат-Эрдэнэ: Оюун-Эрдэнэ сайдын микрофоныг нээе.

Л.Оюун-Эрдэнэ: Тийм ер нь болчихлоо доо тэгээд та хэд маань дахиад дэлгэрэнгүй асуувал хариулаад л явъя. Зүгээр залуучууддаа талархаж байгаа. Мэдээж нээлттэй ил тод ийм л байдлын төлөө бид нар цахим засаглалыг дэмжиж өмнө нь төрийн сангуудыг ч гэсэн ил болгож олон олон асуудал дээр дандаа л нийгэмтэйгээ хамт явсан. Тийм учраас энэ дээр миний хувьд өөрөө ил тод байдлыг хангах ёстой. Энийгээ ч миний хувьд сайн хийнэ. Ер нь яах вэ ингээд нотлогдож чадахгүй байгаа орлоготой холбоотой асуудлыг Засгийн газраас бид нар тэр эрх зүйн орчныг гэхдээ нэлээн тийм өөр агуулгаар орчин үеийн агуулга руу нэлээн оруулаад өргөн барьчихсан байгаа. Тэгээд энэ ингээд батлагдаад явчихвал тэгээд

л орлогоо нотолж чадахгүй бол тэгээд л шууд тэр нөгөө нэг улсын орлого олдог байх. Тэр Сингапурын зарчим зөв шүү дээ. Энийг бид нар ярьсаар л ирсэн. Тэгэхээр миний хувьд бол одоо энэ дээр ямар ч асуудалгүй. Цаашдаа ямар ч асуултад.

Ж.Бат-Эрдэнэ: Батын Батбаатар гишүүн асуулт асууна.

Б.Батбаатар: Нэгэнт энэ асуудал Их Хурлын чуулганаар орох учраас давхацсан болон зарим асуултуудыг хойш нь тавиад цөөхөн зүйл асуух гэсэн юм аа. Орлогоо нотлох тухайд бол нөгөө ийм хариулт нь гүйцэхгүй байгаад байгаа юм. Нөгөө баримтууд буюу хүмүүсийн нэг нүдээр харж нөгөө Монголчуудын ярьдгаар имэрч үзнэ гэдэг шиг тийм зүйл гаргаж ирэхгүй байгаа учраас нэг тэр нь АТГ-аас мэдээлэл гаргаж болохгүй гээд хэлчихсэн юм уу ингээд нэг энэ дээр нэг гацаад байна гэж би хувьдаа ойлгож байгаа. Орлогоо нотлох хэрэгтэй. Тийм тэгж шаардаж байна гэдгийг бол хэвлэл мэдээллийнхэн анх асуухад манай намын зүгээс хэлчихсэн.

Хоёр дахь асуудал нь энэ хурдтай хөгжлийн төлөөх зориг гээд нэг гэрээ байгаа юм. 118 гишүүнтэй. 3 намын хоорондоо байгуулсан гэрээ. Өнгөрсөн 10 сарын хугацаанд энэ гэрээгээ ил гаргаад өгчхөж болдоггүй юм уу? Энэ чинь Монгол Улсын Засгийн газрыг бүрдүүлж байгаа хоорондын улс төрийн намуудын хоорондын харилцааны асуудал шүү дээ. Улсын Их Хурлын нэгдсэн чуулган байнгын хороо энэ болгон дээр ярьж байсан, асууж байсан. Одоо хүртэл гаргаж өгөөгүй ээ. Тэр гэрээгээ ил гаргаад энэ олон түмэнд, иргэдэд сонирхоод байгаа хүмүүст нь өгчхөж болдоггүй юм уу?

Гурав дахь асуудал нь Улсын Их Хурал яг үнэндээ олонх цөөнхгүй болчихсон. 118 гишүүн Улсын Их Хурлын бага ард түмний Засгийн газарт тавьдаг хяналтын үүргийг энэ 118 буюу эрх барьж байгаа хүмүүс хэрэгжүүлж байгаа. Энэ асуудлаа цэгцлэхгүй юм уу? Энэ шаардлагыг байнга тавьж байсан. Магадгүй бидэнд засагт ороогүй хэсэгт хяналт тавих тэр эрх багаж нь байсан бол магадгүй их олон зүйл засагдах байсан байх. Ил далд үнэн худал нь мэдэгдэхгүй янз бүрийн зүйл явж байна. Энэ бүхэн харьцангуй хяналттай байх ёстой.

Дөрөвт нь 3 Их Хурлын дарга өөрчлөгдөж, 3 Ерөнхий сайд өөрчлөгдөж байсан тэр парламентад сууж байсан 4 хүн энэ 126 дотор байгаа. Нэг нь би.

Тэгэхээр улс төрийн шийдвэр 2, 3 газар л гардаг. Нэгд нь Ерөнхийлөгчийн хориг.

Хоёрт нь ҮХЦ-ийн дүгнэлт, 3-д нь МАН-ын Бага хурал, Удирдах зөвлөл. Энд гарсан шийдвэр парламентад орж ирээд төрийн 1.3 жилтэй Засгийн газар, Засгийн газруудын олон энэ үйлдлүүд байр шугамаа сольсон олон асуулт.

Ж.Бат-Эрдэнэ: 4 асуудал байсан. Оюун-Эрдэнэ сайд хариулъя.

Л.Оюун-Эрдэнэ: Тэр эвслийн гэрээ ерөөсөө нууц биш шүү дээ. Тэр ил байж байгаа. Хэд хэдэн Улсын Их Хурлын гишүүдэд өгчих, тэр ерөөсөө нууцын биш. Зүгээр тэрийг ингэж нууц байна энэ тэр гэж л яриад байгаа болохоос биш Германы эвслийн Засгийн газрын гэрээг бидний хувьд аваад нэлээн суусан. Ер нь бол маш зузаан гэрээ байдаг юм байна лээ. Тэгээд тэр гэрээг илүү боловсронгуй болгох л гэж үзсэн. Хамтын хариуцлага хүлээх мөн харилцан бие биедээ мэдээлэл солилцох

гээд ийм олон асуудлууд тусгагдсан байгаа. Тэгээд гэрээнийхээ дагуу бид нар дүгнэж уулзалт хийж байсан. Ийм асуудал байгаа. Үнэхээр санал нэг байна. Хамтарсан Засгийн газар яах вэ мэдээж давуу тал их их байна. Одоо жишээлбэл ингээд төслүүдээ харвал бид нар 10 сарын дотор бараг 4, 5 төслийг ингээд шийдчихсэн байгаа юм. Сул тал нь юу вэ гэхээр аль аль намд нь их гомдол үүсчихдэг юм байна нуугаад яах вэ. Томилгооны ингээд мэдээллийн маш их тийм зөрүүтэй байдал ингээд үүсчихдэг. Тэгээд аль аль талд нь байгаа тодорхой хэмжээний тийм шүүмжлэлтэй байр суурь илэрхийлж байгаа нөхдүүд дээр асар их хэмжээний том хардалт үүсч байна. Ингээд энэ нь өөрөө бас нэг ийм нийгмийн шүүмжлэл болоод яг Батбаатар даргын хэлдгээр наадах чинь олонх цөөнхийн хяналт тэнцэл алдагдаад байгаа юм биш үү гээд ийм асуудлууд болдог.

Тэгээд яах вэ энийг бид нар өнөөдөр ингээд нээлттэй ярьж байгаа нь би бас нөгөө дараа дараагийн Засгийн газруудад, дараа дараагийн одоо ингээд, мэдээж парламентын мэтгэлцээнд энэ бас ийм нэг судлагдахуун болж үлдээсэй гэж бодоод байгаа юм. Нээлттэй, ярилцаад олон талаас нь. Гэрээгээ бид нар тал талдаа л хэрэгжүүлэх ёстой. Тэгээд хэрэгжүүлж чадахгүй бол бас одоо ингээд асуудлууд үүснэ. Тийм асуудлуудыг ингээд яриад явчих нь зүйтэй.

Тэр материал бол ингээд ил байж байгаа даа. Энэ дотор би хийгээд аваад ирчихсэн байгаа юм. Энэ нөгөө бүрдүүлсэн материал. Тэгэхээр тэрийг яах вэ тэр журам нь эд нар болдог тэрийг нийтэд гаргаад байхад ерөөсөө болохгүй юм байхгүй. Миний ХОМ л байгаа гэсэн үг шүү дээ. Тэртээ тэргүй опен дата дээр ингээд байж байгаа л ийм зүйл. Харин ч энэ одоо нээлттэй байдал ингээд шаардагдаж байгаад миний хувьд их талархалтай байгаа. Тэгээд сайн нягтлуулаад тэгээд төртэй холбоотой ямар орлого зарлагын ямар асуудал гарч ирж байгааг би бүгдийг нь ил тод тайлагнахад бэлэн байгаа.

Миний хувьд өнгөрсөн хугацаанд нэг ч Төрийн сангийн зээл, нэг ч төртэй холбоотой асуудал, нэг ч төртэй холбоотой банк, нэг ч төрийн өмчийн томилгоо ямар ч зүйлд оролцоогүй учраас би өөртөө 100 хувь итгэлтэй байгаа. Бүгдээрээ энийг ингээд нягтлуулаад харин ч нийгэм сайн шаардах ёстой. Бүх хүн орлогоо ингээд нотлоод явах энэ нийгмийн хандлагыг би маш зөв гэж бодож байгаа. Тэр хуулиа баталчих хэрэгтэй байна. Тэгээд нотолж чадахгүй бол тэгээд нийтийн албан тушаалтан тэр нь улсын орлого болдог болгочих л хэрэгтэй. Энийг хэдүүлээ нэгэнтээ ийм асуудал гарсан юм чинь манлайлаад хамт хийчих нь Монгол төрд нэг тийм том дэвшил байх. Ингээд л хийгээд явчихъя гэсэн ийм бодолтой байна.

4 дэх асуулт нь юу байлаа Батбаатар дарга аа. Яах вэ юун дээр нэг дэх өдөр манай намын бүлгийн хурал болсон юмаа. Бүлгийн хурал дээр бас энэ дахиад нөгөө минут нь дуусчих шиг боллоо тиймээ.

Ж.Бат-Эрдэнэ: Оюун-Эрдэнэ сайд дахиад нэг микрофон өгье нэг минут.

Л.Оюун-Эрдэнэ: Энэ зүгээр ийм залуучуудын жагсаалтай холбоотой ийм асуудал байсан бол би түрүүн хэлсэн шүү дээ. Би гараад л уулзчих байсан юм. Энэ бол нэг их тийм том асуудал биш. Энэ бол шалтаг. Шалтгаан бол өөр зүйл байсан. Яг өөрийн чинь хөндсөн зүйлтэй холбоотой бас нэлээдгүй олон асуудлууд үүссэн. Энийг ч гэсэн би одоо өнөөдөр тэгээд нээлттэй ярихад бэлэн байна. Яагаад гэхлээр бас л энэ ингээд протоколд олон нийтэд ийм мэдээлэл болж үлдэх ёстой юм чинь тэгэхлээр дараа дараагийн юунууд дээр би нээлттэй хариулаад л явчихъя.

Ж.Бат-Эрдэнэ: Баярмаа гишүүн асуулт асууя.

Ж.Баярмаа: Амрыг эрье. Жудагийн Баярмаа гэдэг хүн асуулт асуух гэж байна аа. Аливаа албан бичиг бол заавал ч үгүй хуулийн үндэслэх хэсэг гэж байдаг хуулийн. Тэгэхээр энэ хүсэлтэд бол ямар хуулийн зүйл заалтыг үндэслэж байгааг нь би олж харахгүй байна энэ дотор. Яах вэ доторх агуулгыг нь уншихаар Үндсэн хуулийн 44.1-ийг барьж байгаа юм шиг байгаа юм. Тэр 44.1-д юу гэж байдаг вэ гэвэл Ерөнхий сайд улсын төсвийн болон бодлогын тодорхой асуудлаар итгэл хүлээлгэх эсэх асуудлыг оруулна гэж байгаа юм. Тэгэхээр энд төсвийн асуудал байхгүй байна. Тэгээд бодлогын тодорхой асуудал гэхээр яг ямар асуудлаар итгэл хүлээлгэхийг хүсэж байгаа юм бэ? Тэгэхээр энд бол тогтвортой, тууштай хэрэгжүүлэхэд бодлогын дэмжлэг шаардлагатай байна гээд нөгөө юугаа тавьчихсан байна л даа. Одоо мөрийн хөтөлбөрөө гэх юм уу. Тэгэхээр энийг хэрэгжүүлэхэд яг ямар дэмжлэг дутаад байгаа юм бэ? Та бүр яг ийм ийм юм дутаад байна гээд ингээд хэлээд өгөөч ээ. Тэгээд хууль зүйн үндэслэх хэсгээ дахиад бас хэлэх хэрэгтэй байна аа.

Хоёрдугаарт, Баялгийн тухай хууль батлагдсан уу? хэзээ батлагдсан бэ? тэгээд энэнтэй холбоотой нөгөө 34 хувиа авна ч билүү, 51 хувийг нь авна ч билүү энэ ажиллагаа юу болж байгаа вэ тиймээ энэ дээр одоо саад бэрхшээл, тоггор үүсээд байгаа юм уу? Нөгөө Ухаа худгийг авна гэсэн ажиллагаа чинь юу болж байгаа вэ? Яагаад гацаад байгаа юм бэ?

Гуравдугаарт, Хөрөнгө хураах тухай хууль. Энэ хууль миний санаж байгаагаар ердөө энэ асуудал дэгдсэний дараа буюу бараг түрүүчийн 7 хоногт орж ирсэн Их Хуралд. Тэгэхээр энэ хууль яагаад ингээд удав аа? Яагаад оруулж ирээгүй мөртөө ингээд энэ хуулийг ингээд оруулахаас асуудал үүслээ гээд ингээд байнга яриад байдаг юм бэ? Яагаад би энэ 2, 3 асуудлыг зориуд хэлж байна гэвэл ерөөсөө баялгаа авах гэсэн чинь болохгүй байна. Хөрөнгө хураах тухай хуулийг батлуулах гэсэн чинь гацаагаад байна. Ухаа худгийг авах гэсэн чинь өгөхгүй байна гээд ингээд нэг ийм хэдэн асуудлыг байнга энэ шүүмжлэлтэй хандаж байгаа хүмүүст наагаад байна аа. Одоо бүр залхаж байна. Бушуу авахыг нь аваач ээ. Яагаад энэ хуулиа эрт оруулж ирээгүй юм бэ?

Дахиад одоо хэрвээ хөрөнгө нь нотлогдохгүй үйлдэл гарах юм бол яг яах юм, хууль байгаа юм уу? Ямар нэгэн хуулиар зохицуулагдах юм уу эсвэл энэ Алтангэрэл сайдын саяхан оруулж ирдэг энэ хуулийг хүлээх ёстой юм уу гэдэг ийм асуулт. Хамгийн сүүлд итгэл хүлээлгэх эсэх тухай асуудал яригдаж байна. Тэгээд би мэдэхгүй байна л даа. Би итгэл хүлээлгэхгүй гэдгээ удаа дараа хэлж байгаа. Хэрвээ Улсын Их Хурал итгэл хүлээлгэнэ гээд гарах юм бол та тэгээд цаашаа ажиллаад явах уу? Одоо түрүүн Номинчимэг гишүүн аягүй зөв асуудал хөндлөө л дөө. Нөгөө уг гарвал чинь шал өөр асуудал байсан шүү дээ уг нь. Тэгээд хэрвээ тэр асуудал буруу гэж үзэж байгаа бол таны өөрийн чинь хэлсэн үг байдаг л даа. Улс төрийн өндөр албан тушаалтнууд бол Япон, Солонгост жижигхэн юмнаас болоод ёс суртахууны хариуцлага хүлээгээд огцордог гээд. Тэгэхээр энэ хүүхэдтэй ч байна уу...

Ж.Бат-Эрдэнэ: Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэ Ерөнхий сайд Жудагийн Баярмаа гишүүний асуултад хариулъя.

Л.Оюун-Эрдэнэ: Огцрох амархан амархан. Тэрэн дээр би санал нэг байгаа. Надад нэг их албан тушаалтай зууралдаад ч байгаа юм байхгүй. Гэхдээ огцорсны дараах үр дагавруудаа тооцох ёстой. Энэ бол бас Монгол төрийн ажил, цааш цаашдын бас Засгийн газар олон сорилтуудтай нүүр тулна. Асуудал бүхэнтэй тулаад л, байнга огцроод байдаг болчихвол гүйцэтгэх засаглал улмаар хэт тогтворгүй засаглал үүсвэл парламентын засаглал дээр эрсдэл учрах учраас энэ хувь хүний шийдэл байж болохгүй л гэж үзээд байгаа юм. Тэрнээс намайг албан тушаалтайгаа зууралдаад байна. Нэг их одоо Ерөнхий сайдын ажилд дуртай хүн гэдэг өнцгөөс хараад бол хэрэггүй ээ гэж бодож байна. Тэгээд бид нар өнөөдөр олон талаасаа яриад парламент Засгийн газрынхаа асуудлыг шийдвэрлэдэг байх нь зүйтэй юмаа л гэдэг агуулгаар энэ асуудлыг оруулж ирэх нь зүйтэй гэж үзсэн юмаа гэдгийг хэлье.

Үнэн үнэн. Үндэсний баялгийн сантай холбоотой стратегийн ордуудын 34 хувьтай холбоотой яг хэлцэл хийгдээд явж байгаа. Эхнийх нь Ухаа худагтай холбоотой асуудал Улсын Их Хуралд өргөн баригдсан. 2 удаа буцаагдсан. Ингээд Улсын Их Хурал дээр одоо ажлын хэсэг гараад миний ойлгож байгаагаар Мөнхтулга гишүүн ахлаад ингээд ажлын хэсэг нь яг хуралдаж байгаа ийм цаг үетэй давхацсан. Тэгэхээр яах вэ энэ хэлцэлтэй холбоотой өмнө нь ОТ-н хэлцэлтэй холбоотой ийм асуудлууд байгаа. Энийг би нэг их одоо тэгснээс болоод, ингэснээс болоод гэж хариулахыг хүсэхгүй байна. Юутай ч цаг хугацааны хувьд ийм байгаа та өөрөө мэдэж байгаа. Энэ цагаан дээр хараар бичигдсэн л зүйл байгаа.

Орлогоо нотолж чадахгүй бол тэр одоо иргэний журмаар нэхэмжлэхтэй холбоотой яах вэ тэрийг бас хөрөнгө хураахтайгаа бас илүү тийм бас нэг тийм мушгиад байгаа зүйлүүд бас байгаа юм. Тэр чинь Алтангэрэл сайд хэдэн сард өргөн баригдлаа. Өнгөрсөн оны 1 сарын 24-ний өдөр Засгийн газраас өргөн баригдсан. Тэгэхлээр 1 сарын 24-нөөс өнөөдөр гэхээр энэ хоёрын дунд заавал үүнээс ингэлээ тэглээ гэдэг зүйл болоод байгаа зүйл юу ч байхгүй. Тэгэхээр энийг хэдүүлээ ингээд хийгээд явах нь зүйтэй л гэж бодож байгаа юм. 9 сард арбитр ОТ-н маргаантай холбоотой асуудлууд ингээд бэлтгэл ажил хангагдаад явж байгаа. Энэ дээр бас нэлээдгүй л ийм асуудлууд үүсэж хэл амтай асуудлууд байж байгаа. Тэгээд Гашуунсухайт, Ганцмод бас одоо холбогдсон өдөр ийм асуудлууд ингээд болж байгаа. Тэгэхээр яах вэ энийг би зүгээр том агуулгаараа манай нийгэм Монголын парламент дүгнэлт хийх нь зүйтэй л гэж бодож байгаа юм. Олон олон ийм том төслүүд хялбар байсан бол бүгдээрээ л явчих байсан байх. Бөөнөөрөө л одоо хамтарч ажилласны үр дүнд бид нар энэ том эрх ашгууд геополитикийн ард гарч байсан. Тэгэхээр бид нар тиймээ тийм ингэчихье гэж хэлэх бол маш амархан. Гэхдээ цаашдаа Монголын парламент Монгол Улсын Засгийн газар гадна, дотнын нэлээдгүй л олон хүнд сорилтуудтай тулна аа. Тийм учраас үүнийгээ бас нээлттэй ярилцаад, ингээд шийдвэрээ гаргадаг байхгүй бол бас нэг ингээд ийм асуудал үүслээ, ийм юм боллоо гэдэг байдлаар төр донслоод байвал цаашдаа ялангуяа энэ том геополитикийн үед 2 том гүрний дунд байдаг Монголын хувьд бас төрийн дархлаа суларна аа. Энэ агуулгаараа л бид нар бүгдээрээ ярилцах нь зүйтэй гэж үзээд байгаа юм шүү.

Ж.Бат-Эрдэнэ: Жудагийн Баярмаа гишүүн тодруулъя.

Ж.Баярмаа: Юу яалаа. Хөрөнгө хураах тухай хуулийг нэг сард өргөн барьсан юм байна. Тэгээд яагаад өнөөдрийг хүртэл хэлэлцэхгүй байгаа юм бол? Энд хэн хариулах вэ? Амарбаясгалан дарга хариулах юм уу эсвэл энийг яаралтай хэлэлцэх

хэрэгтэй шүү дээ. Яагаад хэлэлцэхгүй байгаа юм. Тэгээд бид нараас болоогүй дээ. Гэтэл яагаад бид нартай байнга холбоод байгаа юм. Энэ чинь надад бол бүр пад байхгүй юм байна шүү дээ, түүгээрээ өргөн барьсан, тэгээд яагаад хэлэлцэхгүй байгаа юм. Бушуу хэлэлцмээр байна шүү дээ. Ухаа худгийн асуудал яагаад гацаад байгаа юм. Авах ёстой бол бушуу авмаар байна шүү дээ. Үгүй бүр ингэж л хэлмээр байна. За тэгээд таныг итгэл хүлээлгэнэ гээд ингээд үзчих юм бол та тэгээд ингээд үлдээд итгэгдээд цаашаа үйл ажиллагаа явуулах юм уу? Легитим чанар гэж нэг юм байдаг тиймээ улс төрчийн хувьд. Олон нийт миний бодлоор таныг ер нь хүлээн зөвшөөрөхгүй тал руугаа орчихсон юм болов уу гэж би харж байна. Судалгаагаар 72 хувь нь энэ гадаа явж байгаа жагсаалыг зөв гэж үзсэн байна лээ.

Тэгэхээр нийгэм хүлээн зөвшөөрч байгаа юу, үгүй юү гэдэг дээр та бас нэг хариулт өгөөч ээ. Магадгүй түүгээрээ хийсэн судалгаа байдгийг үгүйсгэхгүй. Таны хүлээн зөвшөөрөгдөх...

Ж.Бат-Эрдэнэ: Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 5 сарын 21-ний өдөр өргөн мэдүүлсэн Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг иргэний журмаар нэхэмжлэх, нөхөн төлүүлэх тухай хуулийн төслийг Баярмаа гишүүн ээ, өнөөдөр бид нар дөнгөж сая энэний өмнө хэдхэн минутын өмнө баталчихсан шүү дээ. Одоо хэлэлцэхээр болсон. Энэ 5 сарын 21-нд өргөн барьсан юм байна шүү. Тэгээд өнөөдөр бид нар сая цохичихлоо шүү дээ. Таныг байхгүй байхад бид нар цохичихсон тийм. Хэлэлцэхээр явж байгаа шүү.

За Оюун-Эрдэнэ сайд хариулъя.

Л.Оюун-Эрдэнэ: Яг бодитой байдлаар Монголын нийгэм өнөөдөр тогтвортой байдлыг л хүсэж байгаа шүү. Судалгаагаар тийм байгаа 60-аас дээш хувь нь төр засаг хямралд орж, хөрөнгө оруулалт гацаж, явж байгаа төслүүд нь зогсож, ирээдүйн хөгжлийн боломжоо улс төрийн ийм асуудлаас болоод алдчих вий дээ гэдэг дээр эмзэглэж байгаа. Тийм учраас бид нар үүнийг олон талаас нь бодох ёстой учраас би өнөөдөр ингээд зориуд ярилцах нь зүйтэй юмаа л гэж үзсэн шүү. Яг бодитой байдал. Огцрох амархан, үнэн. Огцорсны дараах үр дагаврыг бид яаж харж байгаа вэ гэдгээ л өнөөдөр олон талаас нь ярих нь зүйтэй юмаа. Тэгэхээр өнөөдөр бид нар олон талаас нь ярилцаад л тэгээд л та бүхний л онцгой бүрэн эрх асуудал.

Ж.Бат-Эрдэнэ: Энхбаяр гишүүн асуултаа асууя.

Б.Энхбаяр: Монгол Улсын шинэ ардчилсан 1992 онд батлагдсан Үндсэн хууль батлагдсанаас хойш анх удаа Монгол Улсын Ерөнхий сайдад итгэл үзүүлэх асуудал ард түмний төлөөллийн байгууллагаар хэлэлцэгдэж байна. Энэнтэй холбоотойгоор Монгол Улсын шинэ Үндсэн хуулийн энэ заалт хэрхэн зөв цаашид амилж хэрэгжих вэ гэдэг бодлогын хүрээнд хэдэн асуудал хөндөж асууя.

Нэгдүгээрт бодлогын тодорхой асуудлаар Ерөнхий сайдад итгэл үзүүлэх асуудал Үндсэн хуульд тусгагдсан. Ерөнхий сайд маань Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр 14 мега төсөл, баялгийн сан, эрчим хүчний реформ зэрэг Монгол Улсын парламентаас үндсэндээ 90-ээс дээш хувийн дэмжлэгтэй парламентад суудалтай 5 нам тавуулаа дэмжсэн, дэмжсээр ч байгаа ийм асуудлаар бодлогын дэмжлэг хүсээд байгаа нь ямар учиртай юм бэ? Аль нам, ямар гишүүн танаас дэвшүүлсэн энэ бодлогыг дэмжихгүй саад болоод байгаа юм бэ? Нэг дэх асуулт.

Хоёр дахь асуулт. Монгол Улсын Ерөнхий сайдаас ирүүлсэн албан бичигт ард түмний төлөөллийн төв байгууллагаар шийдвэрлүүлье гэсэн байгаа юм. Монгол Улсын Үндсэн хуульд ийм байгууллага байхгүй байгаа. Үндсэн хуульд Улсын Их Хурал нь төрийн эрх барих дээд байгууллага мөн гэсэн байгаа. Өөрөөр хэлбэл Үндсэн хуульд байхгүй байгууллагаар буюу ард түмний төлөөллийн төв байгууллага гэж ямар байгууллагыг хэлээд байгаа юм бэ?

Гурав, Монгол Улсын Үндсэн хуульд хамтарсан Засгийн газар гэдэг ойлголт байхгүй байгаа. Монгол Улсын Засгийн газар гэдэг ойлголт байгаа. Түүнчлэн Чимэд багшийн хэлсэнчлэн эвслийн Засгийн газар гэдэг ойлголт ч Үндсэн хуульд байхгүй. Зөвхөн сонгуулийн өмнө эвсэж байгуулж болох тухай Үндсэн хуульд байдаг. Хамтарч Засгийн газраа байгуулах асуудал болбол улс төрийн хүрээнд ярианы хэллэг байгаа. Энэ ярианы хэллэгийг Улсын Их Хурлын тогтоолоор баталж болох уу гэдэг дээр хуралдаан даргалагчаас асуух гэж байгаа юм. Өөрөөр хэлбэл бид Улсын Их Хурлын гишүүд санал гаргаад Ерөнхий сайдын заасан энэ үндэслэлд заасан асуудлууд дээр өөрчлөх ийм санал гаргах Үндсэн хуулийн боломж байна уу гэсэн ийм асуултыг бас асуухад хүргээд байгаа юм.

Ж.Бат-Эрдэнэ: Оюун-Эрдэнэ сайд хариулъя.

Л.Оюун-Эрдэнэ: Улс төрийн саад үүсэж байгаа учраас энэ бодлого хэрэгжих боломжгүй болж байна аа. Тийм учраас парламент минь үүн дээр өөрийнхөөрөө шийдээрэй л гэдэг ийм шийдэл. Энэ бол аль ч одоо парламентын засаглалтай улсад байдаг л юм шиг. Сонгодог парламент ч гэдэг үг байхгүй. Бид нар сонгодог парламент гэж яриад л байгаа. Ард түмний элчийн хувьд парламент ард түмний нэрийн өмнөөс ажиллах ёстой төлөөллийн төв байгууллага мөн миний бодлоор. Би түрүүн түрүүчийн бас нөгөө нэг ярьж байсан зүйлээ үргэлжлүүлээд ярьчих нь зүйтэй байх.

Улс төрийн асуудлууд үүссэн бодитой. Энэ дээр АН-тай холбоотой асуудал, Хүн Намтай холбоотой асуудал, томилгоо тойрсон асуудал гээд нэлээдгүй ийм том асуудлууд манай бүлгийн хурал дээр болсон юмаа. Тэр асуудлуудад илэн далангүй л би хариулсан. Хамтарсан Засгийн газрын давуу болон сул талын тухай. Сул талынх нь нэг нь үнэн үнэн. Үнэхээр одоо эвслийн эсвэл хамтарсан гэдэг нэр томьёо байхгүй. Ийм шаардлагыг тавьсан. Олонх болчихоод наадах чинь хяналт тэнцэл алдагдаад байна. Тийм учраас энэ улс төрийн шийдвэрээ гаргахгүй бол болохгүй байна гэдэг ийм асуудлыг ярьсан. Миний байр суурь ямар байсан бэ гэхлээр энийг Бага хурал шийдсэн. Бага хурал дээр очоод ярих нь зүйтэй. Зөвхөн бүлгийн түвшинд ярьж хагалж бол болохгүй юмаа гэдэг л ийм байр суурийг хөндсөн. Тэгэхээр энэ өөрөө бодлогод саад учирч байгаа хүчин зүйл мөн л дөө.

Цаашид одоо хамтрахгүйгээр жишээлбэл ийм том том төслүүд явна гэдэгт би бас эргэлзэж байгаа. Парламентын мэтгэлцээн бол маш сонирхолтой болно. Тэр бол зөв зүйл. Гэхдээ өнөөдөр бид нар цаг хугацаа олон улсын геополитик гээд маш их олон зүйлийг л дэнслэх ёстой. Өнөөдөр гаргах шийдвэрийн үр дагаврыг би Ерөнхий сайдын хувьд бүтэн харж чадахгүй байгаа. Нэг үгээр хэлбэл ингээд дангаараа засаглаад одоо явж байгаа бид нар хөгжлийн боломжуудаа бүтэн дайчилж, одоогийн байгаа хурдтай адилхан асуудлуудаа шийдэж чадах уу, үгүй юу. Эдийн засаг түвэгтэй байгаа тариф гээд.

Тийм учраас энэ мөрийн хөтөлбөрөө хэрэгжүүлэхэд хамтарсан Засгийн газар тарах хэмжээний ийм асуудал үүсэж байгаа нь өөрөө энэ чинь бодлогын асуудал мөн биз дээ, биш юм уу. Тийм л учраас би парламентад хандаж байгаа юм. Надад энэ ажлыг өгөх, үлдэх, тэр бол мянга наядах асуудал байгаа юм. Гагцхүү зөв шийдэл яаж гаргах вэ, яаж Монгол Улсын явж байгаа өнөөдрийн бас ингээд одоо шийдвэрлэгдэж байгаа энэ асуудлууд илүү улс төрийн хувьд зөвшилцлийн замаар шийдэгдээд цаашаагаа үргэлжлэх вэ гэдэг дээр л би Ерөнхий сайдын хувьд санаа зовж байгаа улсын Ерөнхий сайдын хувьд. Бид зөндөө л 1.5 жилийн настай, зөндөө л одоо бид нар төслийг тал талаас нь ярьж байгаад гацааж үзсэн. Бид сурцтай энэ дээрээ. Одоо харин бид нар арай өөр замаар явахыг л эрмэлзэж, шүүмжлэлтэй ч гэсэн хамтраад л өнөөдрийг хүртэл ингээд явж байгаа. Тийм учраас цаашдаа ч их олон ийм одоо хамтрах янз бүрийн л асуудлууд яригдах байх. Би энэ нээлттэй үлдээсэй гэж бодож байгаа. Тийм ч учраас би...

Ж.Бат-Эрдэнэ: Надаас бас асуулт асууж байх шиг байна аа. Энэ Улсын Их Хурлын чуулганы хуралдааны Дэгийн тухай хуульд 102 дугаар зүйл дээр Ерөнхий сайдад тодорхой асуудлаар итгэл хүлээлгэх эсэх асуудлыг хэлэлцсэн гэж байгаа. Ирсэн тогтоолын төсөл бол Монгол Улсын Ерөнхий сайдад итгэл хүлээлгэх тухай гэсэн тогтоолын нэртэй байгаа.

Эцэст нь бол Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэд итгэл хүлээлгэхээр тогтсугай гэсэн ийм үг үсэгтэй байгаад байгаа. Ер нь бол агуулгын биш редакцын засварыг бол хийж болно. Жишээ нь энд бол Хурдтай хөгжлийн төлөөх зориг эд нар гээд томоор биччихсэн ч байх юм уу ингээд бас тодорхой редакцын өөрчлөлтийг бол хийх боломж бололцоо бид нарт бас байгаа. Тодруулах уу? Энхбаяр гишүүн тодруулъя.

Б.Энхбаяр: Тэгэхээр бүх юм Үндсэн хуулийн хүрээнд яваасай гэдэг утгаар асуугаад байгаа шүү. Ерөнхий сайдын албан бичигт сонгодог парламентын тогтолцоог төгөлдөршүүлэх хүрээнд дэмжлэг хүсэж байна гэж байгаа. Сонгодог парламент гэдэг бол Үндсэн хуулийн ёсыг хэлж байгаа юм. Манай ардчилсан Үндсэн хууль бол сонгодог парламентын угаасаа загварыг сонгосон. Энэ бол хяналттай, оролцоотой, хариуцлагатай парламентын тухай ярьж байгаа юм. Монгол Улсын Ерөнхий сайд Үндсэн хуулиас гадуур парламентын 94 хувийн нэгдэл бүхий хамтралыг бий болгосноороо Үндсэн хууль дахь ард түмний хяналтыг байхгүй болгосон, харилцан тэнцвэрийг байхгүй болгосон, мөн хариуцлагыг байхгүй болгосон. Өөрөөр хэлбэл хяналтгүй, тэнцвэргүй, хариуцлагагүй парламентыг өөрөө бий болгосон.

Ж.Бат-Эрдэнэ: Оюун-Эрдэнэ сайд хариулъя.

Л.Оюун-Эрдэнэ: Тийм тийм. Энэ стандарт бус Засгийн газар байгууллаа, хяналт тэнцэл алдагдлаа гээд би энэ шүүмжлэлийг маш эрүүл хүлээж авч байгаа, эрүүл хүлээж авч байгаа. Тийм ч учраас би энэ асуудал дээр бас ийм дэмжлэг авахгүй улс төрийн нөхцөл байдал үүсэж байгааг ойлгож байгаа. Би Улсын Ерөнхий сайдын хувьд хамтраад аж ахуйн асуудлуудаа шийдэх нь энэ цаг үеийн Монгол Улсад илүү хэрэгтэй л гэж үзсэн. Үүнээсээ болоод би одоо улс төрийн ийм том блоктой нүүр тулж байгаагаа маш сайн ухамсарлаж байгаа. Аль аль нь давуу болон сул талтай л ийм зүйл. Тийм учраас би үүн дээр санал нэг байна аа.

Хоёрдугаарт өнөөдөр ТББХ-н дээр ярьж байгаа юм чинь зарим нэг тогтоол дээр редакцын засвар хийх энэ дээр манай Энхбаяр гишүүн өөрөө ороод ингээд явах бол бүрэн боломжтой.

Ж.Бат-Эрдэнэ: Болормаа гишүүн асуулт асууя.

Э.Болормаа: Бүгдээрэнд нь энэ өдрийн мэнд хүргэе. Хэд хэдэн гишүүд маань бас хэллээ. Бид Үндсэн хуулийнхаа энэ 44 дүгээр зүйлийг 1992 оны Үндсэн хуулиас хойш ингээд анх удаа хэрэгжүүлэх гэж байна аа. Бид сонгодог парламентаа улам бататгах, бусад парламентын засаглалтай улс орнуудад бол ер нь нэлээн түгээмэл ашиглагддаг итгэл хүлээлгэх гэдэг энэ асуудлыг оруулж ирж байна. Тэгэхээр би энэ хэлэлцүүлгийг ер нь иргэн бүр нүд цавчилгүй анхааралтай хараасай гэж үзэж байгаа юм. Өнөөдөр чуулган дээр ороод бид нар нэлээд асуудлуудыг нээлттэй яриад, тал талаас нь хэлэлцээд Монголчууд бидний хэлдгээр бүгдээрээ хэлэлцвэл буруугүй, бүлээн усаар угаавал хиргүй гээд бүгдээрээ хамтдаа хэлэлцэх байх. Харин ТББХ-н дээр бид нар энэ явц хэлэлцэх явц нь зөв байх талаар дараа дараагийн итгэл хүлээлгэх асуудлууд энэ манай ардчилсан Монгол улсад явагдахад хэрхэн явагдах вэ гэдэг энэ пресиденс буюу одоо цаашдынх нь энэ нэг стандартыг тогтоох юм байгаа юм. Энэ хагас бүтэн сайнаар нэлээн олон хүмүүс уулзалдсан юм шиг байна. Би өнөөдөр өглөө ажил дээрээ ирээд ордон дээр ирэхэд зарим хүмүүс энэ санал хураалтыг далд явуулаач ээ гэдэг ийм юм яриад явж байна. Энэ асуудал байж болохгүй ээ, бид тангараг өргөж ард түмний илч гэж энд сууж байгаа. Бүр тэр дундаа Засгийн газрын сайд нар ийм юм ярьж ордны хуйвалдаан хийх гэж байна. Бид бүхний өмнө саналаа ил тод нээлттэй ярих ёстой. Үндсэн хуульд зааснаар Улсын Их Хурлын гишүүн саналаа ил өгнө. Зарчмын зөрүүтэй санал гарч өөрчлөгдөөгүй тохиолдолд л ингэнэ гэж байгаа юм.

Энэ далд яриан дунд юу болдог вэ гэхээр нөгөө сандал суудлын хэрүүл болдог. Өө би сайд болно. Чи сайд бол оо. За бүгдээрээ ингэе. Энгийг сайхан бүгдээрээ ил тод нээлттэй ярих ёстой. Тэгэхээр бид Төрийн байгуулалтын байнгын хороо бид энэ дээр хариуцлагатайгаар энэ сонгодог парламентыг төгөлдөржүүлэхийн бүр нэг хэсэг нь гэж үзэж байгаа юм. Энэ итгэл хүлээлгэх процессын үр дагавар нь юу байхаас үл хамаарч энэ процессыг зөв хийх нь бидний хариуцлага. Энэ 126 гишүүнтэй энэ шинэ парламентын бидний хариуцлага гэж харж байна. Тэгэхээр би энэ дээр намын бага хурал дээр бүүр нэг гишүүний хэлсэн зүйлийг хэлмээр байгаа юм. Ерөнхий сайд аа, танд хань болохгүй байгаа энэ сайд нараа эсвэл болиоч ээ, Засгийн газарт нь ороод суучихдаг, тэгээд одоо далдаар санал хурааа гээд өөрийнхөө Засгийн газрын эсрэг санал өгөх гээд явж байдаг, хэн ч албадаж сайд болгоогүй шүү дээ. Өргөдлөө өгөөд ажлаа өгч болно шүү дээ. Сайд томилох бүрэн Ерөнхий сайдын эрх. Тэгэхээр энэ процесс дээрээ Төрийн байгуулалтын байнгын хороо илүү нягт анхааръя. Энгийг анхаарч үзэж байгаа өнцөг буланд байгаа Монголчууд энгийг нүд цавчилгүй хараарай гэж би хүсмээр байна.

Ж.Бат-Эрдэнэ: Санал хэллээ, үг хэллээ. Пүрэвдорж гишүүн асуулт асууна.

Б.Пүрэвдорж: Тэгэх дээр энэ тогтоолын төсөл бол нэг өөрөө бас нэг асуудалтай байгаа юм л даа. Тэгэх дээр 1992 оны Үндсэн хуулийн заагдсан тэр 44 дүгээр зүйл бол гол агуулга нь одоо энэ дээр бол одоо 14 мега төсөл эрчим хүчний реформ, бүсчилсэн хөгжлийн асуудал гээд энэ асуудлуудыг тавиад энд энгийг шийдвэрлэх ёстой асуудлаар итгэл хүлээлгэх тухай асуудал ярьж байгаа юм. Тэгэх дээр өнгөрсөн хугацаанд манай парламент бол Ерөнхий сайдын оруулж ирсэн бүх

л зүйлийг ерөнхийдөө бүгдийг нь дэмжээд явж байсан. Аль аль нь нам нь дэмжээд сөрөг хүчин ч гэсэн бид нар бас тодорхой хэмжээгээр дэмжээд ингээд явсан. Тэгэхлээр энэ 44 дүгээр зүйл чинь ямар агуулга байдаг юм гэх дээр жишээ нь Засгийн газар төсвийн асуудал оруулж ирлээ. Тэгэнгүүт төсвийн алдагдлыг 0.5 хувьд барь гэдэг ийм Засгийн газрын үгүй Их Хурлын шийдвэр гараад энийг буцаасан тохиолдолд энийг ингэж барих боломжгүй ээ. Яагаад гэвэл эдийн засгийн нөхцөл байдал ийм байна аа. Тийм учраас энэ асуудлыг би одоо ингэж 0.5-д бол төсвийн алдагдлыг барьж чадахгүй ээ.

Тийм учраас миний энэ асуудлыг энэ 2 хувь төсвийн алдагдлыг 2 хувьд нь өргөн барьсан тэр төслийг баталж өг, аль эсвэл надад итгэл үзүүлэх тухай асуудал ярьж өг гээд. Тэгээд хэрвээ энд итгэл үзүүлэх тухай тогтоол орж ирэх юм бол тэрийг нь дэмжсэн тохиолдолд шууд тэр 0.5 хувиар энэ 2 хувиар төсвийн алдагдалтай батлах тэр юу шийдвэр нь шууд хэрэгжээд явдаг. Хэрвээ Их Хуралд итгэл үзүүлэхгүй бол огцордог ийм л зүйл юм байгаа юм. Тэгэх дээр энэ дээр бол одоо бид нарын хувьд ямарваа нэгэн тийм Их Хурлаас энэ Засгийн газрын хэрэгжүүлэх гэж байгаа тэр бүх асуудлуудыг эсэргүүцэж унагаасан ийм тохиолдлууд бараг байхгүй ээ. Тийм учраас энэ бол одоо орлого нотлох тухай л асуудал байсан. Энэ нэг ийм энийг одоо МАН-ын Бага хурал руу чирээд оруулсан. Тэгээд энэ дээрээ АН-ыг Засгаас гарах тухай л ганцхан асуудал яригдсан. Ийм л зүйл байгаа.

Тэгэх дээр энэ дээр бас Ерөнхий сайд ч гэсэн өөрөө тэр доторх Бага хурлынх нь бичлэг задарсан байна лээ. АН-аас гаргаад цаашаа явчихъя гэж хэлсэн байдаг. Тэгээд ингээд ийм байдлаар ингээд явах дээр нэг яг энэ хамтарч байгаа засаг чинь энэ бүх буруугийн буруу чинь бүгдээрээ АН-ын буруу болж хувирдаг. Энэ хэдэн сайд нар чинь бүгдээрээ л хамаг байдгаараа чадлаараа л зүтгэсэн шүү дээ. Эдийн засгийн урт хугацааны хөгжлийн асуудал, барилга хот...

Ж.Бат-Эрдэнэ: Пүрэвдорж гишүүнд нэг минут өгье.

Б.Пүрэвдорж: Барилга, орон сууцжуулалтын асуудал, хууль зүйн асуудал, байгаль орчны асуудал гээд хамгийн галтай, хамгийн хэл амтай тэр бүх яамдуудыг бүгдийг нь хариуцаад ажиллаад бид нараас болж, АН-аас болж энэ хэдэн сайд нараас болж асуудал үүсээгүй л гэдгийг би хамгийн гол нь хэлмээр байгаа юм. Тэгээд энэ дээр бас одоо энэ Үндсэн хуулийн тэр суурь зарчим чинь ийм шүү. Энэ шалтгаан чинь буруу шүү гэдгийг л би бас хэлмээр санагдаж байна.

Ж.Бат-Эрдэнэ: За үг хэллээ. Батнайрамдал гишүүн.

О.Батнайрамдал: Баярлалаа. Та бүхэнд бас өдрийн мэнд хүргэе. Тэгээд яах вэ өнөөдөр ингээд Монгол Улсад болж байгаа үйл процессын яах вэ ганц нэг жижиг деталь руу орох юм бол бид нар яриад дуусахгүй л дээ. Шүүмжлээд дуусахгүй үг үсэг рүү орох юм бол. Гэхдээ энэ болж байгаа үйл процессыг бид нар том зургаараа дүгнэлт хийх ёстой. Яг юу болоод байгаа юм бэ. Зөвхөн 2, 3 намын хамтрал яригдаад байгаа юм уу, энэ том зургаар нь бид нар заавал нэг харж дүгнэлт хийх орон зай гэж харж байгаа юм. Тэгээд энэ хавар чинь бас маш өндөр зохион байгуулалттайгаар зөндөө л юм боллоо. Гэхдээ энэний ард ингээд яригдахгүй үлдчих вий гэсэн нэг том сэдэв байгаад байна л даа.

Олон жил олон 10 жил бид нар бас хүсэж маш том хүлээлт байж байгаад арай гэж батлуулж авсан Үндэсний баялгийн сангийн тухай хууль хэрэгжээд яг баялгийн

хэлцлүүд яваад эхэлсэн. Яг өнөөдрийн байдлаар нэг ч хэлцэл нь эцэслэгдээгүй л, нэг ч хэлцэл эцэслэгдээгүй. Том зургаараа миний хувьд энэ дээр бас богинохон дүгнэлт хийчихмээр байна. Энэ ганцхан Монгол Улсад яваад байгаа зүйл биш ээ. Байгалийн баялгаас хэт хамааралтай орнууд олон байдаг. Тэрэн дээр явдаг хамгийн том толгойны өвчин яг өнөөдөр Монгол Улсын улс төрийн процесс дээр болж байгаа үйл явц бол байгалийн баялгийн шударга хуваарилалтыг бид нар хийж чадах уу, үгүй юу, энэний ард гарч чадах уу, үгүй юу гэсэн тэмцэл л явж байгаа. Цөөхөн хэдхэн бүлэглэл энэ байгалийн баялгаас орж ирж байгаа орлого дээр эзэн сууж хяналтдаа байлгасаар байх уу, эсвэл үндэсний баялгийн сангаар дамжуулж орон сууц, эрүүл мэнд, боловсрол руу хөрөнгө оруулалтыг хийх тэр шуудууг бид нар нээж өгч чадах уу. Энэ л асуулт шүү дээ.

Яг өнөөдөр Монгол Улсад болж байгаа, улс төрд болж байгаа процесс. Би та нарт хэлье. Замби, Перу, Боливи, Нигер, Индонез бид бүхний сайн жишиг авдаг Чилид ч гэсэн яг болж байсан процессууд байгаа. Энэ дээр why nations fail гээд улс орнуудын доройтлын шалтгаан гээд 2024 оны эдийн засгийн нобелийн шагналт 2 хүний бичсэн ном бүгдийг нь тайлбарлаад өгчихсөн байгаа. Энийг бүгдээрээ уншаасай гэж би хүсэж байгаа юм. Яг Монгол Улсад явж байгаа энэ улс төр дээр явж байгаа процесс яаж баялгийн сан дээр очоод гацдаг. Энэ орнууд дотор Папуа Гвиней гээд нэг улс байгаа. Яг Ерөнхий сайд нь баялгийн сангаа байгуулаад мөнгөжүүлж чадалгүй улс төрийн нөлөөнөөс болоод унаж байсан ийм л асуудал. Тэгэхээр энэ том зургаараа бид нар харж дүгнэлт хийж хэрсүү байж шийдвэр гаргахгүй өнөөдөр нэг жижигхэн деталь руу орох тоолондоо бид нар төөрнө өө. Төөрөгдүүлэх PR ч хангалттай явуулна. Тэгэхээр том зургаар бид нар өнөөдөр дүгнэх ёстой.

Тийм учраас Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр бид нар 126 гишүүнтэй болсон шүү дээ. Ийм юманд автахгүй...

Ж.Бат-Эрдэнэ: Батнайрамдал гишүүнд нэг минут өгье.

О.Батнайрамдал: Яг л ийм улс төрийн тогтворгүй байдал дандаа үүсэх вий. Эндээс хамгаалахын тулд бид нар Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлт орж 126 гишүүнтэй болсон. Тэгэхээр одоо таны манлайлж байгуулсан Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр 126 гишүүнтэй болсон энэ шинэ парламент маань 10 сар хүрэхгүй дахиад итгэл хүлээлгэх үү, үгүй юү гээд ингээд л яг сууж байна. Тэгэхээр энэ дээр та дүгнэлтээ хийх хэрэгтэй. Ард түмэн бүгдээрээ харж байгаа. Нээлттэй ярих хэрэгтэй. Энэ нь буцаад дараа дараагийн ийм асуудал гарахад протоколоороо бүгдэд нь үлдэх ёстой л гэж бодож байгаа. Асуултдаа хариулт авчихъя.

Ж.Бат-Эрдэнэ: Оюун-Эрдэнэ сайд хариулт өгье.

Л.Оюун-Эрдэнэ: Хэдүүлээ бас ингээд яг бодитой үнэнийг ярьж чадахгүй л байна л даа. Засгийн газрын хувьд алдаа бол энэ нөгөө том төслүүдийг арай хурдан явуулчихсан байгаа. Тэгээд том төслүүдээ явуулчихсан юм чинь одоо АН нэг их хэрэгтэй юу, үгүй юү гэдэг ийм том асуудал босож ирсэн нь нууц биш шүү дээ. Шахсан хүмүүсийн дийлэнх нь л тийм л юм ярьсан шүү дээ. Тийм учраас би Пүрэвдорж даргын асуултад АН-ын сайд нар маш сайн ажилласан, маш сайн ажилласан. Би үнэхээр чин сэтгэлээсээ талархаж байгаа. Тийм ч учраас би энэ нөгөө хамтарсан Засгийн газар зөв гэдэг идеологи дээр зогсож байгаа юм. Цаашдаа

ч гэсэн олон асуудлыг бид нар хамтарч шийдэх энэ хаалга нээлттэй байгаасай гэж би хүсэж байгаа учраас энэ асуудлыг ингээд нээлттэй ярьж байгаа юм.

Гашуунсухайт яваад хүрээд ирсэн дараагийн Засгийн газар зурагдчихсан байсан. Бодитой АН дотор бас дараагийн удирдлагуудынх нь асуудлууд тэр зурагдсан Засгийн газартайгаа очоод нийлчихсэн байсан. Энэ бол шалтгаан. Ингээд маш том хэмжээний блок үүсчихсэн. Би хэлээд байна шүү дээ. Зүгээр энэ асуудал байсан бол би залуучуудтай аль эрт очоод уулзчих байсан юмаа гээд. Харамсалтай нь суурь шалтгаан нь өөрөө энэ. Ерөөсөө л дараагийн нөгөө л сандал суудлын асуудал, нөгөө л томилгооны асуудал. Тийм ч учраас хамтарсан Засгийн газрын гэрээн дээр улсын эрх ашиг нэгд, намын эрх ашиг хоёрт, хувийн эрх ашиг гуравт гэдэг энэ үгийг би албаар оруулсан. Ийм л алдаанаас болж бид нар дандаа л Засгийн газраа фэйлдүүлсэн. Тэгээд нэг ийм сээрэн дунгуу шиг чөтгөрийн тойрог руу орсон. Энэ дээр энэ стратегийн ордын хэлцэлтэй холбоотой энэ олон олон асуудалтай холбоотой бүх асуудлууд нэгдэж байгаа нь бодитой үнэн. Ордон дотор би хүч алдаж байгааг дэндүү сайн ойлгож байгаа.

Одоо тэгээд нэг бие биеэ хараад нэг их худлаа ярьцгаагаад яах вэ дээ хэдүүлээ. Бодитой л зүйлээ ярь. Хэн нь ямар хүн ярьж байна, дараагийн санал хураалтын дараа хэн нь ямар сайд болоод явах нь вэ та нар ард түмэн маань бүгдийг нь хараарай. Ямар жижиг эрх ашгаас болж ямар том хөгжлийн боломжийг устгаж байгааг бас тогтоож аваарай. Тэгээд л одоо нэг хэдүүлээ ярьчихаад л уулзсанаасаа өөр юм яриад яах вэ. Бодитой үнэнээ хэл л дээ. Бодитой бүх үнэнийг чинь би хариулъя гэж байна шүү дээ.

Ж.Бат-Эрдэнэ: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Хэлэлцэж байгаа асуудалтай холбоотойгоор үг хэлэх гишүүд байвал нэрсээ өгье. Батнайрамдал гишүүнээр тасаллаа. Номтойбаяр гишүүн.

Н.Номтойбаяр: Өөрийнхөө асуусан асуултад тодорхой хариу бол авч чадаагүй ч гэсэн бусад гишүүдийн асуусан асуултаар ер нь ойлголоо. Одоо чуулган дээрээ орно. Ерөнхий сайдын зүгээс хэд хэдэн үг хэллээ. Энэ огцруулах, ажлаа өгөх энийг бас улс төрийн зорилгоор шалтаг болгож цаана нь бас шалтгаан зорилго нуугдаж байгаа гээд. Миний байх байх эсэх асуудал мянга наядах асуудал гээд. Тэгэхээр ажлаа өгөх өгөхгүйтэй зууралдаад байгаа юм биш байна гэж ойлголоо. Тэгээд хамгийн гол нь энэ тогтоолын төсөл дэмжигдэх, дэмжигдэхгүйгээс үл хамаараад Оюун-Эрдэнэ гэж хувь хүний улс төрийн карьер цаашдаа үргэлжлэх үү, үргэлжлэхгүйгээс үл хамаараад яах аргагүй сонгодог парламент энэ парламентын хуулиар баталгаажсан төрийн хөгжлийн бодлогууд тууштай үргэлжлэх л ёстой. Тэгээд энэ дээрээ хатуу байгаарай.

Тэгээд ний нуугүй хэлэхэд одоо ингээд гишүүд бүгдээрээ л мэдэж байгаа. Түрүүн би хэвлэл дээр хэлсэн. Бүгдээрээ л нэг айдаст автаад байна, больцгоо итгэл үнэмшлээрээ саналаа өг. Улсын Их Хурал ямарваа нэгэн байдлаар барьцаалагдаж, ямарваа нэгэн байдлаар айдас хүйдэст автаж энэ хуруугаа дарж хэрхэвч болохгүй. Энэний төлөө би энэ парламентад бага насандаа орж ирснээс хойш ийм л байсан. Зовлон жаргалыг зөндөө л үзсэн. Тэглээ гээд эр зориг ердөөсөө мохоогүй шүү. Тэглээ гээд ард нийтийн итгэх итгэлийг ердөөсөө алдаагүй буцаад л гараад л ирсэн ийм байгаасай л гэдгээ хэлмээр байна.

Ж.Бат-Эрдэнэ: Сандаг-Очир гишүүн.

Ц.Сандаг-Очир: Өнөөдөр чинь хувь заяа нь хөндөгдөөд ирэхээр хурал чуулгандаа суудаг өдөр байдаг юм байна аа. Би бас жил харлаа. Үндсэндээ энэ Их Хурал бүтцийн байгууллага Байнгын хороодын ажил үнэхээр хэцүү байсан шүү дээ яг үнэнийг хэлэхэд. Харин энэ парламент энэ Засгийн газарт асар их дэмжлэгтэй байсан. Оруулж ирсэн асуудал болгоныг нь дэмжиж байсан сайд нарын. Харин одоо сайд нар бол харин Их Хурлынхаа гишүүний ажлыг харин муу хийсэн шүү. Хурал чуулгандаа ирдэггүй байсан шүү. Орж ирээд хуруугаа уншуулаад гараад явдаг байсан шүү. Энийг бүгд мэдэж байгаа. Ирц бүрдүүлэх гэдэг асуудал Улсын Их Хурлын Байнгын хороодын толгойны өвчин болсон байсныг бүгд мэдэж байгаа. Тэгээд нэг ийм төсөв батлах үеэр гэдэг юм уу, эсвэл нэг ийм томилгоо огцрох асуудлаар л ингээд бүгд орж ирдэг ийм. Энийг чинь ард түмэн надаар хэлүүлэлтгүй сайн мэдэж байгаа байх гэж ингэж бодож байна. Өнөөдөр бүр 92 хувийн ирцтэй хуралдаж байна шүү дээ нэгд.

Хоёрт, харин энэ цаашдаа дараагийн засаг ер нь хэн байхаас үл хамаараад сайд нар хэн байхаас энэ парламентынхаа ажлыг та нар маань сайн хийгээч ээ л гэж би хүсэх гэж байгаа юм. Энэ Байнгын хорооныхоо хуралдаан дээрээ суудаг байгаач ээ гээд. Тэгээд өнөөдөр энэ сайд нар маань юу болж байна вэ гэхээр ерөөсөө надад хамааралгүй миний хамаарах асуудал биш бол ерөөсөө ингээд огт падлийгүй, огт суудаггүй ийм л байдалтай явж ирсэн. Тэгээд таны гишүүний үндсэн үүрэг бол энэ хурал чуулгандаа суух асуудал шүү дээ. Эндээс чинь энэ парламентын ажил, нэр хүнд, итгэл үнэмшил төрнө шүү дээ. Тийм учраас би энэ одоогийн сайд нар болоод дараагийн шинэ төрөх сайд нарыг би бол энэ хурал чуулгандаа суудаг парламентынхаа ажилд оролцдог, энэ ажилдаа илүү анхаараач ээ. Тэрнээс тэр засгийнхаа ажил руу өнгөрсөн хугацаанд анхаарлаа хандуулж явсаар байгаад өнөөдөр парламентын нэр хүндийг шаланд унагаж байгаа шүү дээ яг үнэнийг хэлэхэд энэ.

Манай Бага хурлын шийдвэр юу гэж гарсан бэ гэхээр ерөөсөө энэ Засгийн газрын Ерөнхий сайдын асуудал яриагүй ерөөсөө энэ засгаас АН-ыг гаргах асуудлыг л ярьсан. Цаашдаа дангаараа явна уу, хамтарсан байна уу энэ эрх нь нээлттэй байгаа. Олон нийтийн хандлага ч тийм байгаа юм байна лээ. Энэ Засгийн газар энэ нөгөө суудал авсан олон намууд бүгдээрээ том бүлэг болчихсон, хяналтын асуудал хаягдсан юм байна. Бүгдээрээ найзан дундаа явсан юм байна. Тийм учраас цаашдаа энэ засаглалынхаа асуудлаар тэр сонгодог хэлбэрээр нь хяналтаа сайжруул гэвэл АН л засгаас гарчих. Эд нар маань ч өөрсдөө тэгж ярьж байгаа юм шиг байна шүү дээ. Тэгээд бусад намуудтай хамтраад явчихад болохгүй юм байхгүй. Энэ төр засгийн ажил нэг их гацаад байх юм байхгүй юм шиг харагдаж байгаа юм. Та бүхэн маань буцаад ч засагт орно гэдэг нүүр ч байхгүй байлгүй дээ бодвол. Тэгэхээр улс оронд хэрэгтэй нь тэр юм байна лээ. Хяналт нь сайн байж байж энэ төр засгийн ажил нээлттэй явах юм байна.

Би юу хэлэх гэж байна вэ гэвэл би энэ Засгийн газрыг тогтвортой байгаасай гэдэг тал дээрээ илээр байна уу, нууцаар байна уу энэ дээр саналаа өгнө. Ерөнхий сайдад итгэл үнэмш үзүүлнэ гэдэг дээр би саналаа өгнө тодорхой. Өнөөдөр яаж байна. Яам, Засгийн газрын ажил бүгд зогсчихсон. Энэ Их хурал, Засгийн газрын ажлыг хараад бүгд ажил бүх шатандаа зогсчихсон. Үндсэндээ 5 сар ажил хийсэнгүй, сандал суудлын төлөө хэрүүл хийлээ шүү дээ. Тэгээд энэ чинь хэзээд нь ажил хийдэг хугацаатай билээ бид нар чинь. Ингээд бүтэн 5, 6 сарыг алдлаа шүү дээ бид нар. Тэгээд энэ жил чинь л гол ажил хийх бүрэн эрхийн хугацааны гол жил шүү дээ.

Тийм учраас би бол энэ засаг төр тогтвортой байгаасай гэдэг тал дээр анхнаасаа ч байр сууриа хэлж байсан энэ байр суурин дээрээ ч итгэл үнэмшлээрээ саналаа өгнө. Тэр хэн сайд байна вэ, хэн ямар засаг байхаасаа илүүтэйгээр надад төр засаг тогтвортой, гадна талдаа тэгж харагддаг энэ том ажлууд нь яваасай л гэдэг үүднээсээ. Тэрнээс нэг их энэ намуудад сайд нарт...

Ж.Бат-Эрдэнэ: Сандаг-Очир гишүүнд баярлалаа. Өнөөдөр 25 гишүүнээс 23 гишүүн ирж өнөөдөр нэг хурал шиг хурал болж байгаа шүү. Энийг бас нэг хэлчихье. Батбаатар гишүүн үг хэлье.

Б.Батбаатар: Түрүүн асуулт асуухад зарим зүйлүүдийг нь орхиод бусад гишүүд ч гэсэн давхардуулаад их олон асуулт асуух байх гэсэн үүднээс орхиод асуусан. Ер нь энэ парламентын түүх, Засгийн газрын түүх бол ер нь Ардын намын цагаан байшин дотор шийдэгдсээр л ирсэн. Үндсэн хууль энэ парламентын Их Хурлын тухай байдаг юм уу, Засгийн газрын тухай хууль Үндсэн хуулийнхаа хүрээнд шийдэгдсэн нь их бага, ер нь байхгүй дээ. Ардын намын цагаан байшин дотор ямар шийдвэр гарна энд ордон дотор засаг өөрчлөгдөж байдаг тийм л шийдвэр явсаар байгаад ирсэн. Ардчилсан холбоо эвсэл засаг барьж байсан 4 жилд 51 гишүүн сууж байж ирц нь хүрч Улсын Их Хурал хуралддаг. 50 гишүүн нь Ардчилсан холбоо эвсэлд байсан. Мөн л Ардын намын шийдвэрээр засаг огцорч байдаг. Нэг удаа цөөнх байхдаа ч тэр, бусад цаг үед ч гэсэн тэр. Тэгэхээр өнөөдөр энэ болж байгаа улс төрийн процесс бол сайн талуудыг дагуулж байна, саар талыг ч дагуулж байна. Сайн нь юу вэ гэхлээр Ардын намын цагаан байшинд гарсан шийдвэр Улсын Их Хурлын босгоор орж ирээгүй нь бас нэг талдаа сайн. Тэр Ардын намын дарга нь өөрөө тэндээ шийдээд нэг талд нь гаргаад явбал явна л биз.

Улсын Их Хурал дээр Ардын намын шийдвэр орж ирэхээ больж байна гэдэг эрх зүйт төр буюу энэ парламентын ёсны үндэс суурь болж байна гэж ойлгож байгаа. Энэ тухай байр бас сууриудаа түрүүн тодруулж асуух гэж байгаад орхичихсон. Нэгдсэн чуулган дээр илэрхийлээсэй гэж үзэж байгаа. Мэдээж парламент өөрийн гэсэн сөрөг хүчинтэй байх ёстой. Үндсэн хуульд Улсын Их Хурлын тухай хуульд сөрөг хүчин гэдэг үг өгүүлбэр байхгүй ээ гэдэг нэрийн дор засагт хамтарсан нам нь цөөнх хийгээд л яваад байсан. Засгийн газар нь кабинетын зарчмаар ажиллах ёстой. Тийм болохоор бид нар энэ аливаа асуудал бид нарын ингээд өнөөдөр төвөгшил үүсгээд байгаа асуудлууд юу вэ гэхлээр дандаа л улс төрийн шийдвэрээс үүдэж байгаа л асуудал шүү дээ. Өнөөдөр сайн муу, сайхан муухай, сайн ажилласан, муу ажилласан гэдэг асуудлууд ерөөсөө байхгүй шүү дээ. Саяын Байнгын хороон дээр ч ярьж байна, нэгдсэн чуулган дээр их олон гишүүд асуулт асууж, үг хэлэх байх.

Бид иргэдийн асуугаад байгаа асуултуудыг энэ 126 гишүүн болж өгвөл бүгдээрээ нийлүүлж байгаад асуучихмаар байгаа юм. Юу юу шаардаад байгаа юм, юуг асуугаад байгаа юм, ямар байр суурь нь зөв гэж итгээд байгаа юм. Иргэд бүгдээрээ 100 хувь нэг талд байхгүй шүү дээ. Өөр өөрийн гэсэн өнцөгтэй, өөр өөрийн гэсэн олон талын оролцоотой. Тэр олон талын оролцоог Их Хурлын гишүүд маань асуугаад тэр иргэдийн асууж байгаа зүйл дээр авсан хариулт өөрсдийнхөө итгэл үнэмшил, дээрээс нь мөрийн хөтөлбөр дээрээс нь улс орноо бодоод, хариулт шийдлээ гаргаасай гэж хүсэж байна. Тэгээд асуултад авч хариулт авч чадаагүй зүйлүүдийг бас саяын утгаар нь ойлгоод, нэгдсэн чуулганы үеэр ярьчихвал сайн байна гэдэг ийм саналыг хэлье ээ. Баярлалаа.

Ж.Бат-Эрдэнэ: Баярмаа гишүүн. Жудагийн Баярмаа.

Ж.Баярмаа: Яг энэ одоо энэ Үндсэн хуулийн 44.1 бол яг энэ итгэл хүлээлгэх гэж байгаа энэ асуудал хоёр бол ерөнхийдөө бараг зөрчилдөж байна. Тодорхой бодлогын асуудлаар гэсэн яг ямар тодорхой бодлогын асуудал гэдэг нь байхгүй байна. Төсвийн асуудлаар гэсэн төсвийн асуудал мэдээж байхгүй. Яагаад гэхээр тодорхой бодлогын асуудлуудыг энд бичсэн энэ бодлогын асуудлуудыг бүгдийг нь дэмжчихсэн. Ёстой түрүүн хэн хэллээ Энхбаяр гишүүн байна уу ер гаруй хувьтай бүгд дэмжээд ингээд батлаад явж байгаа. Тэгэхээр ямар бодлогын асуудал гацаад байгааг дахиад л ойлгосонгүй би бол хувьдаа. Тэгээд маш тодорхой тодорхой түрүүн асуулт асуусан боловч тэгээд яг хаанаа гацаад, яагаад байгаа нь ингээд тодорхойгүй үлдлээ. Ер нь гацаагүй шинжтэй юм шиг байна. Гацсан бол Их Хурал өөрөө л гацаасан байна. Их Хурлын субъектүүд Байнгын хороо юм уу мэдэхгүй. Яагаад оруулж ирэхгүй байсан тэр бол сөрөг хүчинтэй ч юм уу ямар ч хамаагүй юм байна.

Дээрээс нь АН бол маш сайн ажилласан гэдгээ хаа хаанаа хүлээн зөвшөөрлөө. Хамаг чухал асуудлуудыг барьж аваад ажилласан гэдгийг хүлээн зөвшөөрлөө. Тэгээд эцэст нь нэг ийм надад сонин бодол төрөөд л үлдлээ. Монгол Улсад ер нь төрийн залгамж чанар, залгамж халаа гэж бараг байхгүй юм биш үү. Оюун-Эрдэнэ гэдэг Ерөнхий сайд бол ер нь МАН юм байна. бүүр цаашилбал төр юм байна. Тэгээд Оюун-Эрдэнэ Ерөнхий сайд байхгүй бол Монгол төр гацах юм байна. Монгол төрийн бодлого алдагдах юм байна. Энд залгамж чанар, залгамж халаа, залгамж чанар гэж юу ч байхгүй юм байна гэдэг нэг ийм бодол төрлөө. Уг нь МАН чинь 104 жилийн түүхтэй ууган хүчин, бас ч гэж тогтолцоо энэ өнгөрсөн хугацаан дахь бүх асуудал бол МАН-тай холбоотой Монгол Улсын түүх. Алдаа нь ч тэр, оноо нь ч тэр, 2021 оны хувьсгал 2024 оны Үндсэн хууль анхны алдаатай оноотой ч гэсэн. Хэлмэгдүүлэлт 1945 оны тусгаар тогтнол, НҮБ-д элсэх гээд энэ бүх асуудал гарцаа байхгүй МАН-тай уг нь холбоотой. Гэтэл өнөөдөр МАН ингээд ганцхан Ерөнхий сайд байж байж тэр бүх төрийн бодлого нь явдаг эс бөгөөс гацдаг нэг ийм юм руу орж байгаад харамсаж байна МАН-д маш их харамсаж байна. Ийм л бодол төрлөө дөө. За баярлалаа.

Ж.Бат-Эрдэнэ: Пүрэвдорж гишүүн асуултаа асууна.

Б.Пүрэвдорж: 2016 оноос хойш МАН төр барьсан. Тэгээд нэг өөдтэй нэг ширхэг ч бүтээн байгуулалт байхгүй. Дарханыхаа замыг одоо хүртэл тавьж бараг дуусаагүй ийм л байгаа. Энэ хугацаанд маш их олон хулгай явсан. Төсвийн хулгай, ковидын хулгай, нүүрсний хулгай, оффтейкийн хулгай, ногоон автобусны хулгай, тээврийн хулгай, Си зөвшөөрлийн хулгай, хуурамч шатахууны хулгай гээд асар их хулгайнууд. Хамтарсан засгийн нэг харамсалтай зүйл бол энэ олон хулгайнууд бүгдээрээ далд орсон. 14 мега төсөл 300 дэд төслийн цаана одоо ингээд. Өнгөрсөн хугацааны энэ их бүх зүйлүүд бүгдээрээ дарагдаж алга болж байгаад харамсаж байгаа. Төрийн өмчийн компаниуд бүүр замбараагүй. Жишээ нь Тавантолгой төмөр зам дээр 980 хүн ажиллаж байгаа, тэрний 100 хүн нь гэрээгээр ажиллаж байгаа, байхгүй. Улаанбаатар хотод 180 хүн ажиллаж байгаа. Тэд нарын нэлээн олонх нь тэр төмөр зам дээр очиж үзээгүй байна гэж байгаа шүү дээ. Гэтэл яг хувийн 200 хэдэн километр төмөр зам дээр 280 хүн тэр Тавантолгой дээр ажилладаг, хоёр ээлжээр ажилладаг. Улаанбаатар хотын захиргаанд нь есхөн хүн үйлчлэгчтэйгээ нийлээд 9 хүн ажиллаж байгаа юм. Энэ юу илэрхийлж байна вэ гэвэл өнгөрсөн хугацаанд тэр сонгуульдаа ажилласан бүх хүнийг бүгдийг нь төрийн өмчийн

компани төрийн байгууллагуудаар бүгдийг нь аваачиж шигсэн гэсэн үг. Одоо юу байдаг юм тэнд аваачиж бүгдийг нь дүүргэсэн гэсэн үг. Жишээ нь Эрдэнэс үгүй ээ, Тавантолгой төмөр замын захирал нь муурандаа цээживч авсан байгаа шүү дээ. Үгүй ямар замбараагүй байна.

Тэгээд энэ бүх зүйлийг ерөөсөө хянадаг ийм хяналтгүй болчихлоо гэдгээ одоо энэ Сандаг-Очирын хэлдэг зөв. Тийм учраас энэ ард түмэн биднийг 2024 онд эрх баригч нь эрх баригч шиг бай, сөрөг хүчин нь сөрөг хүчин шиг бай гэдэг ийм л даалгавар өгсөн. Тийм учраас энэ АН-ын гишүүд сайд нар засгаас гарах өргөдлөө өглөө. Сөрөг хүчин дээр очих гэж байгаад их баяртай байна. Ер нь цээжин цээжиндээ, бөгс нь бөөр нь бөгсөндөө байсан нь дээр. Энэ хамтарч энэ их хулгайг хаацайлах ёсгүй. Тэгэхдээ баримт алга болдоггүй гэдгийг хэлье.

Ж.Бат-Эрдэнэ: Батнайрамдал гишүүн үг хэлнэ.

О.Батнайрамдал: Яг л ийм тогтворгүй Засгийн газар 1.5 жилдээ явж ирсэн. Том төслүүд нь урагшилдаггүй байсан. Бүүр 1992 онд ардчилсан Үндсэн хуулиа баталж байхад 5 дугаар цахилгаан станцын асуудал яригдаж байсан байдаг шүү дээ. Протокол дээр нь байдаг. Өнөөдөр бид нар хийж бүтээгүйгээ хүртэл явж л байгаа. Яг энэ асуудлууд байсан учраас Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлт хийж бид нар лоббид автдаг 76 биш, 126 болох ёстой юм байна аа. Эх орны ашиг эрх ашиг дээрээ нам хамтрахгүйгээр одоо бүгдээрээ нэгдэж, энэ том төслүүд урагшлах юм байна гэж агуулгаар 126 гишүүнтэй болсон гэж ойлгож байгаа. Тэгэхээр энэ 126 гишүүнтэй парламентын магадгүй хамгийн том сорилт нь ингээд 10 сарын дараа ирж байна бид нарт. Яг урьд нь тэр хийж байсан алдааг бид нар дахиад давтах уу эсвэл бид нар илүү эрүүлээр харж, эвлэлдэн нэгдэж шийдэл гаргаж явах уу.

За энийг бол ард түмэн бүгдээрээ харж байгаа шүү. Энэ 126 тэр Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөө хийсэн яг тэрүүн дээрээ байж чадах нь уу. Энэ хэдэн төслөө ингээд урагшлуулж чадах нь уу. Хамгийн гол нь энэ байгалийн баялгийн шударга хуваарилалтыг хийж чадах нь уу. Тэр Оюу Толгойн асуудлыг шийдэж чадах нь уу. Үндэсний баялгийн сан үнэхээр мөнгөжих нь үү, эсвэл дахиад л нэг яриа болоод ингээд үлдэх нь үү. Тэрнээс биш ард түмэн бол бид нарын ярьж байгаа нэг деталийг тоохгүй ээ, зүгээр л энэ Монгол Улсын их потенциалыг ашиглаад бид нар урагшлаад чадах нь уу, үгүй юу. Энэ ард түмний өмч гэж Үндсэн хуулиараа тунхагласан байгалийн баялгийн шударга хуваарилалтыг бид нар бид нарт орон сууц, эрүүл мэнд болоод очих нь уу, үгүй юу. Миний хүүхдэд боловсрол болоод очих нь уу, үгүй юу, надад эрүүл мэндийн чанар болоод очих нь уу, үгүй юу л гэж харж байгаа байхгүй юу.

Тэгэхээр Монгол Улсад өнөөдөр тохиолдож байгаа энэ улс төрийн асуудал олон оронд тохиолдож байгаа. Яг бидний харж байгаа Латин Америк, Африкийн орнууд, Азийн орнууд давдаг нь даваа гараад, улс эх орноо хөгжүүлээд л явсан. Давж чадаагүй нэг нь яг хэдэн элит тэр баялгийг контролдож байгаа хэдэн нөхдийнхөө дунд ороод л тэгээд л чөтгөрийн тойргоосоо хэзээ ч гараагүй зөндөө орнууд байж л байгаа.

Тэгэхээр эрхэм гишүүд минь бүгдээрээ энэ дээр том зургаараа харж, том агуулгаараа харж шийдлээ л гаргах ёстой. Харин ямар ч шийдэл гарсан бид ямар ч үйлдэл хийсэн ард түмнийхээ өмнө нээлттэй, ил тод, нуух, хаах юмгүйгээр л явуулах ёстой. Энэ бол зарчим шүү. Бид нар ийм амлалтыг өгч ард түмнээсээ сонгогдсон.

Тийм учраас яг энэ амлалтынхаа хүрээнд, ямар ч шийдвэр гарсан тэдний өмнө нээлттэй ил тод ярьж, нээлттэй ил тод саналаа өгч бид нар шийтгэлээ шийдэх л ёстой. Гэхдээ энэ асуудал явсаар байгаад бас Улсын Их Хурлаар орж ирдэг нь бол зарчмын хувьд маш зөв гэж харж байгаа. Дараа дараагийн парламентууд гишүүд бас яг энэ үед юу болж байсан бэ, хэн юу хэлж байсан бэ гээд бүх протоколыг нь дараа нь авч үзэх болов уу л гэж бодож байна. Магадгүй 4 жилийн дараа, 8 жилийн дараа, мэдэхгүй аягүй бол хэдэн жилийн дараа ч юм уу.

Тэгэхээр том агуулгаа харж бид бүхэн энэ дээр эх орныхоо төлөө эх орныхоо эрх ашгийг нэгдүгээрт тавьж шийдвэр гаргаасай л гэж чин сэтгэлээсээ хүсмээр байна. Баярлалаа.

Ж.Бат-Эрдэнэ: Сайнзориг гишүүн үг хэлье.

П.Сайнзориг: Баярлалаа. Ер нь тэгээд Монгол Улсын нийтлэг эрх ашгийг л бодож бид нар шийдвэрээ гаргах ёстой байгаа юмаа. Би яг одоо 40 настай. 1984 онд 4 дүгээр цахилгаан станцыг барьснаас хойш бид нар цахилгаан станцын эх үүсвэр барьж чадаагүй байгаа. Учир нь зүгээр хоосон улс төржилт. Дулааны нэг станц барьсан Амгалангийн алдаг оног ажилладаг ийм л байгаа юм. За уул уурхайн томоохон төслүүд явж байгаа. Бараг манай Хэрэг эрхлэх газрын дарга Учрал сайд бас онож хэлж байсан шүү дээ. Цэнгүүн гишүүнтэй чацуу ураны төсөл хөдөллөө гээд. Энэ одоо томоохон гэдэг юм уу сигналууд эдийн засгийг сэргэх энэ итгэл найдварыг авчрах энэ төслүүд бас энэ улс төрийн хувьд ойлголцож байж бол гарсан юмаа.

Тэгэхээр энэ ер нь зүгээр тодорхой түвшиндээ бас хуйвалдаан гэхээсээ илүүтэй Монгол Улсын нийтлэг эрх ашиг. Энэ 30 жилийн юу гэдэг юм явж ирсэн хий эргэсэн эс үйлдэхүйгээр чөдөрлүүлчихсэн байсан 30 жилийн уг нь тушааг нь гаргаад бид нар бас нэг хөдөлж болох юм байна гэдэг итгэл найдвар авчирч байсан юм болов уу гэж бодож байгаа юм. Тэгээд энэ дээр өнөөдөр цэг тавих уу, үгүй юу гэдэг дээр яриад байх шиг байна.

Би юун түрүүнд бас нэг 2 зүйлийг зарчмын хувьд хэлмээр байна. Сая Болормаа гишүүн, Батнайрамдал гишүүний хэлж байгаатай би санал адилхан байна. Нууц санал хураалт энэ тэр гэж байж болохгүй ээ. Ард түмэн энийг ойлгохгүй. Тийм учраас ил одоо парламент ёсныхоо зарчмаар энэ зүйлүүдийг хийгээд явах ёстой. Энийг нууц горим руу оруулна гэдэг бол цаана нь хуйвалдаан явна л гэсэн үг. Өнөөдөр яах вэ зүгээр ингээд нэг хэд сонгогдоод ирэхээр нэг сайд болох ийм тачаалддаг юм байна лээ. Энэ тачаал ерөнхийдөө энэ одоо бүх зүйлүүдийг сэдрээдэг. Намтар дээрээ ямар ч байсан нэг сайд гээд биччихэж улс төрөөс буух ёстой гэж ийм нэг ийм жижигхэн бодлууд бас байдаг юм байна аа улс төрчдөд. Энэ амбиц гэдэг юм уу, энэ зүйлүүд ерөнхийдөө энэ парламент ёсыг, намын төлөвшлийг ер нь байхгүй болгодог юм байна. Энийг одоо харж л байна залуу хүний хувьд. Тэгэхээр энэ зүйл рүүгээ явж байгаа учраас ил тодоор явах ёстой.

Хоёрдугаарт, сая бас нэг гишүүн хэллээ. Ерөнхий сайдын оруулж ирсэн энэ тогтоол дээр зарчмын зөрүүтэй санал гаргаж болохгүй гэж бодож байна. Ерөнхий сайд өөрийнхөө бүрэн эрхийн хүрээнд оруулж ирсэн зүйлүүдийг бид нар дэмжинэ, дэмжихгүй гэдэг л санал гаргана хураана уу гэхээс биш тэрэн дээр нь засвар оруулж байгаад асуудлыг шийдэж өгнө гэдэг бол байж болохгүй. Тийм учраас би энийг зарчмын хувьд хэлмээр байгаа юм. Тэгээд яах вэ энэ зовлон бол 2019 оны Үндсэн

хуулийн өөрчлөлт өө. Бид хэд энэ зүйлийг бодитой авах ёстой. Парламент дээр хуулийг 50 дээр нэмэх нь нэг босгоор баталдаг энэ заалтыг оруулж байхад миний бие хуульч хүнийхээ хувьд эсэргүүцэж байсан юм. Энэ ингээд олонх парламентыг бүрдүүлж байгаа олонхоо цөөнхийн гарт барьж өгдөг парламент ёсоо хоёрхон парламентын дараа байхгүй болгох энэ заалтыг орууллаа гэдгийг 2019 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг хийж байхад би ажлын дэд хэсэгт ажиллаж байсан хүний хувьд хэлж байсан.

Харин Үндсэн хуулийг нийт сонгогдсон гишүүдийн 75, органик хуулийг 66 хувиар ердийн хуулийг хуралдаанд оролцсон гишүүдийн олонхоор шийдээд явж байж энэний цаана мэтгэлцээн дээрээ ямар нэгэн байдлаар парламент ёс ажиллаж байх ёстой байхгүй юу. Гэтэл өнөөдөр бид нар 50 дээр нэмэх нь нэг гэдэг энэ зангыг парламент дээрээ тавьчихаад энэ Ерөнхий сайд хэн байхаас үл хамаараад улс төрийн манлайлал авч явах гэж байгаа хүн чинь энэ бодлого шийдвэрийг авч явах бүтцээ л харна шүү дээ. Тэгэхээр энэ бүтцийг оруулаад ирэхээр Үндсэн хуулийн бус ч гэдэг юм уу, стандарт бус ч гэдэг юм уу ийм зүйлүүдийг ерөөсөө ярьж болохгүй ээ. Хүссэн хүсээгүй энэ Оюун-Эрдэнэ гэдэг хүн ажиллаж байгаа эсэхээсээ хамаараад дараа нь хэн ч байсан хамаагүй яг тэр хүний зовлон яг адилхан байх болно оо. АН намгүйгээрээ ч гэдэг юм уу явах асуудал одоо бас хэцүү. Энийг бодитой л хэлчихье.

Байнгын хорооны түвшин дээр чинь өнөөдөр хуралдаж чадах юм уу гэдгээ бодох л хэрэгтэй. Тэгэхээр энийг одоо бас яах вэ зүгээр хууль зүйн талаасаа би хэлж байгаа юм. Өөрөө эргээд бид нар 2019 онд парламентыг ийм хамтрал руу явуулахаас өөр аргагүй байдал дээр буюу Үндсэн хуулийн өөрчлөлтийг хийчихсэн юмаа, хийчихсэн юм. Энийг хууль тогтоомжийн ангилал батлах квотоо зөв болгож байж парламент ёсыг бэхжүүлдэг орнууд авч явдаг болохоос биш манайх шиг бүх хууль...

Ж.Бат-Эрдэнэ: Үг хэллээ. Байнгын хорооны гишүүнийхээ хувьд бас нэг таван үг хэлчихье гэж бодож байна аа. Өнөөдөр Оюун-Эрдэнэ гэдэг МАН-ын дарга, Оюун-Эрдэнэ гэдэг Ерөнхий сайдаас бүх юм хамааралтай юм шиг зарим нэгэн гишүүн ярьж байх шиг байна. Асуудлыг зөв хараасай гэж бодож байна. Энэ урд талбай дээр жагсаж байгаа залуучууд маань ч гэсэн энийг олж харж байгаа байх аа. Ер нь харж байгаа байх гэж бодож байна. Урьд өмнө нь бид нар 76 гишүүнтэй байсан, нүүрсний хулгай гарсан, Хөгжлийн банкны хулгай гарсан энэ хулгайг хаана зогсоож чадах юм гэхээр хяналттай парламент байж байж л зогсооно шүү дээ. Өнөөдөр гишүүдийн ярьж байгаа зүйлтэй би санал нэг байна. Үнэхээр ардчилсан зарчмын дагуу үнэхээр хэлэх ёстой үгнүүдээ хэлж л байна. Энэ яагаад ийм болсон юм бэ гэдгийг бид нар эргээд нэг харчих хэрэгтэй байна шүү дээ. 126 гишүүнтэй, холимог тогтолцоотой, зарим нэг хэсэг нь спэсээр орж ирдэг, араасаа ямар нэгэн тойргийн хамааралгүй, ямар нэгэн гишүүд сонгогчдынхоо хамааралгүйгээр бүх үнэ боломж бололцоотой үгээ хэлдэг ийм тогтолцоог бид нар чинь оруулж ирсэн шүү дээ. Энэ хулгайтай тэмцэхийн тулд энэ том тогтолцоог оруулж ирсэн. Өнөөдөр 5 нам эвсэл оролцож ирсэн энэ парламент дээр сууж байна шүү дээ. Урьд нь хэзээ ийм байсан юм. 76 гишүүн болоод нэг хэсэг нь 2 нам хоорондоо өрсөлдөөд л байдаг нэг нь цөөнх болж орж ирдэг, цөөнхийнхөө аманд одоо төсөв дээр нь хэдэн төгрөг тавингуут л нь цөөнх нь дуугарахаа больчихдог. Ийм л байсан шүү дээ.

Өнөөдөр одоо энэ дээр зөв зүйтэй юм хэлж байгаа хүмүүс ихэнх нь спэсээр орж ирсэн хүмүүс байгаа шүү дээ. Энэ парламентыг зөв харагдуулж байгаа шүү дээ. Яах вэ цаашаа туршлагажаад явах л байх АН-ын зарим сайд зугтаагаад гарчихсан

одоо орж Ерөнхий сайд нь зугтаж гарчхаад одоо хүртэл орж ирж чадахгүй нөхцөлд байж л байгаа шүү дээ. Тэгэхээр бид нар бол 126 гишүүнтэй энэ зөв тогтолцоо руу орчихсон өнөөдөр ч гэсэн ард иргэд маань харж байгаа байх гэж бодож байна. Зоригтой үгээ хэлж чаддаг болчихсон байх гэж бодож байна. Энэ 25 жил миний хувьд 25 жил энэ төрд ажиллалаа. Хамгийн гол асуудал бол өнөөдөр бид нар төр тогтвортой байх асуудал л байгаа шүү дээ. Төрөөрөө тоглодог, түрүүн хэлээд байгаа биз дээ. Ер нь бол төрөөрөө тоглодог Засгийнхаа ар тал эрх ашгаа бодоод ингээд явчихдаг. Ингээд энэнээсээ болоод ерөөсөө төр нь тогтворгүй, ажлаа хийж чаддаггүй тэгээд энэ өнөөдрийн байгаа нөхцөл байдлын хувьд бол мэдээж хамтраад явах ийм нөхцөл байдлыг бид нар харсан. Монголчууд хоорондоо эвсдэг байх хэрэгтэй, монголчууд хоорондоо учраа олдог байх ёстой, нам эвслүүд хоорондоо учраа олдог байх ёстой ингээд явах ийм зүйтэй гэсэн энэ үндэслэл дээр л бид нар бол хамгийн гол асуудлаа бол харж цаашаа явах нь зүйтэй байх аа л гэж бодож байгаа.

Ингээд мэдээж сая Ерөнхий сайд өөрийнхөө үгээ хэлсэн байх. Ерөнхий чуулган дээр орж өөр ч дэлгэрүүлээд ярих байлгүй гэж бодож байна. Ерөнхий агуулгаараа бол энэ төртэйгөө зууралдаад байх юм байхгүй. Гол зарчмын асуудлуудаа бариад явах нь зүйтэй байх мэдээж одоо эндээс Улсын Их Хурлын гишүүд өөрсдөө нээлттэй саналаа гаргаад явах нь зүйтэй байх гэж өөрөө ч хэлсэн. Тэгээд гишүүд маань тэгээд саналаа гаргаад явна аа гэж одоо ойлгож байгаа.

Ингээд хэдүүлээ үг хэлж дууслаа. Гишүүд үг хэлж дууслаа. Одоо санал хураалт явуулна. Гишүүд санал хураалтдаа бэлдье. Горимын санал Бямбацогт гишүүн.

С.Бямбацогт: Ер нь бол Оюун-Эрдэнийн Засгийн газар сайн ажилласан. Хамтарсан Засгийн газарт бас ажилласан АН-ын сайд нар ч сайн ажилласан. Олон том төслүүд хөдөлсөн тэгээд өнөөдөр энэ асуудал хэлэлцэгдэж байгаад харамсаж байгаа. Гэхдээ сая зарим гишүүд хэлж байна. Уулын мод урттай, богинотой олон хүн сайнтай, муутай. Тэгээд бүгдийг нь хавтгайруулаад л юу гэдэг юм олон сонгогдсон гишүүд гэдэг юм уу, эсвэл сайд нар гэдэг юм уу, хуралдаа суудаг, суудаггүй гээд л ингээд яриад байх шаардлагагүй. Яг онцлоод онцлоод ярих хэрэгтэй. Тэгэхгүй ингээд л хоорондоо битүү хатуу үг хаялцаад л, хоорондоо тэгээд нэг үл ойлголцол үүсээд л тэр нь одоо үзэн ядалт болоод л ингээд төр тогтворгүй болдог. Ингээд л эцэст нь ард түмэн зовдог.

Тийм болохоор энэ үл ойлголцол гэдэг юм баймааргүй байгаа юм. Улс төрийн дэлхийн геополитикийн нөхцөл байдал амаргүй байна. Монгол Улсын үндэсний эрх ашиг эв нэгдэл гэдэг юм бидэнд хэрэгтэй. Монголчууд нөгөө эвтэй байхдаа хүчтэй гэж ярьдаг. Тэгээд энэ бүгдийг бодоод энэ чуулганы хуралдааны дэгийн тухай хууль хараад ингээд сууж байхад тодорхой асуудлуудаар Байнгын хороо, чуулган хуралдана, тодорхой асуудлуудаар яаж ямар байдлаар зохицуулж асуудлаа шийдэх вэ гэдгээ бас маш нарийссан дэгтэй байгаад байгаа юм. Ингээд харж байхад бол энэ Ерөнхий сайдад итгэл хүлээлгэх эсэх асуудлаар Байнгын хороон дээр санал хураах шаардлагагүй байгаа.

Түрүүн Сандаг-Очир гишүүн хэлсэн шүү дээ. Сандаг-Очир гишүүн шаардлагагүй, ач холбогдолгүй зүйлээр санал хураах ямар хэрэгтэй юм бэ гэж. Энэ Цэцийн гишүүнийг томилох, Ерөнхий сайдыг томилох, чөлөөлөх, Ерөнхийлөгчийг огцруулах эсэх асуудал гээд олон асуудал дээр Байнгын хороон дээр санал хураалт

явуулна. Заримыг нь ил, зарим нь нууц санал хураалт явуулна гээд биччихсэн байгаа. Тэгвэл Ерөнхий сайдад итгэл хүлээлгэх эсэх асуудал дээр бол Байнгын хороо санал дүгнэлт гаргана гэсэн болохоос нууцаар буюу илээр санал хураалт явна гэсэн зүйл байхгүй байгаад байгаа юм. Тийм болохоор Байнгын хороон дээр санал хураалгах шаардлагагүй ээ. Чуулган дээр тэртээ тэргүй эцсийн үр дүн гарах учраас чуулган дээр санал хураалтаа явуулъя гэсэн горимын санал байна. Энд ямар ч ач холбогдолгүй учраас. Тэгээд Дэгийн тухай хуульд зохицуулалт байхгүй байна. Дэгийн тухай хуульд бол бусад асуудал дээр нь зохицуулалттай. Байнгын хороо ил болон далд нууцаар санал хураалт явуулна зохицуулалттай мөртөө яг Ерөнхий сайдад итгэл хүлээх асуудал дээр 102 дугаар зүйл дээр асуудал байхгүй байгаад байгаа юм. Санал хураалт явуулна гэсэн.

Тийм болохоор тэгээд санал хураалт явуулаад ч тэр нь чуулган дээр очоод хураагдахгүй. Тийм болохоор Байнгын хороон дээр санал хураалт явуулах шаардлагагүй гэсэн горимын санал гаргаж байна. Энэ горимын саналаар санал хураалт явуулж өгөөч ээ гэж хуралдаан даргалагчаас хүсэж байна.

Ж.Бат-Эрдэнэ: Горимын санал гарчихлаа тиймээ. Энэ хуулийн ингэж байгаа шүү. 102.3 дээр энэ хуулийн 102.1-д заасан тогтоолын төслийг Улсын Их Хурлын нийт гишүүдийн олонх баталснаар саналаар баталсан бол Ерөнхий сайдад итгэл үзүүлж тухайн асуудлыг дэмжсэнд тооцно. Тогтоолын төслийг батлаагүй бол Ерөнхий сайдыг огцорсонд тооцож энэ тухай тогтоол баталсанд тооцно гэж байгаа. Тэгэхээр бид нар чуулганд оруулна. Чуулганд оруулахаар энэ хажууд Хурлын дарга байж байна. Хурлын дарга бол мэдээж яг энэ заалтаар бол тогтоолын төслийг тогтоолын төслийг баталъя гэснээр бол санал хураахаар болчихоод байгаа юм л даа. Баталъя. Энэ дээр тайлбар хаанаас гарах вэ. Алив Баасандорж дарга бас нэг тайлбар хийгээдэх дээ. Тэгэхдээ горимын санал гарчхаад байна шүү дээ энэ чинь. Горимын санал гарчхаад байгаа шүү. Горимын санал гарчхаад байхад хураахгүй гэсэн юу байх вэ дээ энэ чинь. Алив Баасандорж дарга.

Оюун-Эрдэнэ сайдад нэг үг өгчихье.

Л.Оюун-Эрдэнэ: Төрийн байгуулалтын байнгын хороо болон чуулганы нэгдсэн хуралдааны санал хураалтад Ерөнхий сайд өөрөө оролцох нь зохисгүй гэж бодож байна. Энэ бол ёс зүйн асуудал. Тэгээд геологи минийх, санал та нарынх. Тэгээд эрхийг Монголын парламент өөрөө шийдтүгэй. Тийм учраас ирцээс намайг гаргаж өгөх нь зүйтэй болов уу гэсэн ийм санал байна.

Ж.Бат-Эрдэнэ: Оюун-Эрдэнэ сайдыг ирцээс гаргая. Тэгээд саналаа хураачихъя тийм. Ажлын хэсэг, ажлын хэсэг ч юу байх вэ. Баасандорж дарга. Баасандорж даргын микрофон өгье.

Б.Баасандорж: ТББХ-ны дарга, гишүүддээ энэ өдрийн мэндийг хүргэе. Ерөнхий нарийн бичгийн дарга Баасандорж. Саяын Бямбацогт гишүүний хэлсэн саналтай холбоотой хариулъя. Энэ бол оруулж ирж байгаа асуудал буюу Улсын Их Хурлын тогтоолын төсөл нь Засгийн газар хууль санаачлагчийн хувьд оруулж ирээгүй асуудал. Хууль санаачлагч 3 субьекттэй тогтоолын төсөл болон хууль тогтоомжийн төслийг оруулдаг. Энэ оруулж ирсэн асуудал бол Монгол Улсын Ерөнхий сайд Үндсэн хуулийн 44 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан бүрэн эрхийнхээ хүрээнд оруулж ирж байгаа асуудал. Өөрөөр хэлбэл бусад Улсын Их Хурлын тогтоолын төслөөс ялгаатай нь хэлэлцэх эсэх гэж байхгүй. Анхны

хэлэлцүүлэг гэж байхгүй, эцсийн хэлэлцүүлэг гэж байхгүй. Шууд Байнгын хороогоор дэгийн тухай хуулийн 102 дугаар зүйлд заасан журмын дагуу хэлэлцэгдээд чуулганд орох асуудал байгаа.

Өөрөөр хэлбэл Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 102.2 дээр холбогдох Байнгын хороо таслал, ТББХ Ерөнхий сайдад итгэл хүлээлгэх тогтоолын төслийг хуралдаанаараа хэлэлцэх гэж байгаа юм. Асуудлыг хэлэлцэн санал, дүгнэлт гаргаж нэгдсэн хуралдаанд оруулна гэдэг маань өөрөө ТББХ орж ирсэн асуудлаар энэ тогтоолын төслийг дэмжих үү, дэмжихгүй юу гэдэг дээр санал хураагаад хэлэлцэн шийдвэрлэж санал хураагаад санал, дүгнэлтээ чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулах нь зүйтэй гэж үзэж байгаа Дэгийн хуулиар.

Ж.Бат-Эрдэнэ: Гишүүн горим гаргачихлаа тийм үү. Энийг хараадхаач.

Б.Баасандорж: Саяын Бямбацогт гишүүний сайдын гаргасан горимын саналаар бол Ерөнхий нарийн бичгийн даргын хувьд санал хураагдаж болохгүй гэж үзэж байна. Чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 13.2 дээр 2 дахь өгүүлбэр дээр нь хуралдаанаар одоо хуралдаанаар хэлэлцэх асуудалд ороогүй буюу мөн тухайн санал нь хуулиар тогтоосон журмыг зөрчиж байгаа бол санал хураалт явуулахыг хориглоно гэж байгаа юм. Тэгэхээр энэ 102.2-оор ТББХ санал хураалт явуулах ёстой. Тэгэхээр санал хураагдах явуулах ёстой асуудлаар санал хураахгүй гэдэг асуудал оруулж байгаа нь өөрөө энэ 13.2-той зөрчилдөнө өө гэж үзэж байна.

Ж.Бат-Эрдэнэ: 102 дугаар 102.2-т заасны дагуу холбогдох Байнгын хороо ТББХ Ерөнхий сайдад итгэл хүлээлгэн тогтоолын төслийг хуралдаанаараа хэлэлцэн санал дүгнэлт гаргаж нэгдсэн хуралдаанд оруулна гэж заасантай зөрчилдөж байна гэж үзэж горимын саналыг санал хураах боломжгүй гэж үзлээ. За Баярбаатар гишүүн.

Б.Баярбаатар: Би горимын санал гаргая аа. Өглөө бас бүлгүүд хуралдсан. ТББХ хуралдаад санал хураах цэг дээрээ ирж байна. Гишүүд янз бүрийн байр суурьтай байгаа нь илт байгаа нэг. Хоёрт, энэ Их Хурлаас сонгогдож томилогдож чөлөөлөгддөг бүх албан тушаалтнууд нууц санал хураалтаар явдаг. Жишээлбэл өнгөрсөн 7 хоногт бид нар Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнийг чөлөөлөхдөө бид нар өөрөө өргөдлөө өгчихсөн хүнээс нууц санал хураалтаар явуулсан. Тэгэхээр Ерөнхий сайд мөн Их Хурлаас томилогдож, чөлөөлөгддөг албан тушаалтан. Гүйцэтгэх засаглалын тэргүүн нэг. Хоёрт, гишүүдийн энэ байр суурийг харгалзан үзэж дараа нь энэ Бямбацогт сайдын энэ гаргасан саналтай би адил байна. Энэ нийгмийн нөхцөл байдал, энэ аюулгүй байдал, энэ нийгмийн талцал хуваагдлыг бид энэ парламент нь өөрөө бий болгож болохгүй гэж харж байгаа.

Тийм учраас энэ ТББХ-н дээр энэ санал хураалтыг нууцаар нууц санал хураалт дотроо 2 янз буюу цаасаар. Цаасаар хураах. Цахимаар биш цаасаар хураах эд нар. Их Хурлын чуулганд танилцуулах дүгнэлт дээр мөн төрийн байгуулалт хэрвээ энэ горимын санал дэмжигдээд явбал Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд бас нууцаар, цаасаар хураалгах ийм Байнгын хорооны бас дүгнэлтэд тусгахыг хүсэж байна. Ийм горимын санал байна аа. Санал хураалгаж өгнө үү?

Ж.Бат-Эрдэнэ: Горимын санал дотроос тэр Их Хурал дээр гэдгийг нь хасчихвал яасан юм. Зөвхөн одоо Байнгын хороон дээр гэдэг юм хэрэггүй биз дээ.

Зүгээр чуулганы эрхэнд халдаж байж болохгүй шүү дээ бид хэдүүлээ. Тэгэхээр тэрийг нь хаслаа шүү. Хасаад зөвхөн нууцаар бөгөөд цаасаар хураалгая гэсэн саналын томьёолол горимын санал.

Баярбаатар гишүүний гаргасан горимын саналаар санал хураалт явуулъя. Баярбаатар гишүүний гаргасан горимын саналыг дэмжье гэсэн саналаар санал хураалт явуулъя. Санал хураалт. Тийм нууцаар, цаасаар. Уучлаарай. Би юу алдчихлаа, дэг алдчихлаа. Энэ санал хураалтыг гарчихсан байгаа даа уг нь. Санал хураалтыг хүчингүй. Үгүй ээ дэмжээд, сая болсон уу хүмүүс, болоогүй тиймээ. За би санал хураалтад бэлтгэсэн юуг алдчихлаа дэг алдчихлаа. Тийм болохоор энэ санал хураалтыг хүчингүй болгоё гэсэн санал гаргаж байна. Энэ санал хураалтыг хүчингүй болгоё гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Би бас хуруугаа хийхгүй юм байна шүү дээ, хийх юм байна шүү дээ. Санал хураалтдаа бэлдье.

Санал хураалт явуулъя. Баярбаатар даргын гаргасан Баярбаатар гишүүний гаргасан саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт. Хүчингүй болгоё. Санал хураалтад бэлдье, бэлдчихсэн үү. Одоо санал хураалт хүчингүй болгоё гэсэн санал хураалтыг явуулъя аа. Санал хураалт.

23 гишүүнээс 20 гишүүн дэмжиж, санал хураалт хүчингүй боллоо. За одоо горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя. Санал хураалт.

Санал хураалтад 23 гишүүн оролцож, 16 гишүүн дэмжиж, 69.6 хувиар санал дэмжигдлээ.

Санал дэмжигдсэнтэй холбогдуулаад Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10.6 нууц санал хураалтыг санал хураах хуудсаар явуулах бол гишүүдээс бүрдсэн тооллогын комисс байгуулна. Нууц санал хураалт явуулах дүнг гаргах журмыг тооллогын комисс боловсруулж хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар батална гэж байна.

Тооллогын комисс бүрдүүлье. Тооллогын комисст оролцох гишүүд саналаа өгөх үү? За Баярбаатар гишүүн, Баярмаа гишүүн, Номинчимэг гишүүн. Эхлээд тоогоо тооцох уу тоогоо. 3-аар явчих юм уу? За Баярбаатар, Батбаатар, Баярмаа. За энэ 3-аар баталчих уу? За байж байгаарай, гишүүд байж байгаарай.

Монгол Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоол. 2025 оны 6 сарын 2-ны өдөр. Дугаар 7. Тооллогын комисс байгуулах тухай. Тийм.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны Дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.6 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлын ТББХ-ноос Тогтоох нь:

1. Монгол Улсын Ерөнхий сайдад итгэл хүлээлгэх тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар нууц санал хураалтыг зохион байгуулж, дүнг танилцуулах үүрэг бүхий тооллогын комиссыг Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар, Б.Батбаатар, Ж.Баярмаа нарын бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

2.Нууц санал хураалт явуулах, дүн гаргах журмыг боловсруулж, санал хураалтыг зохион байгуулж, дүнг Байнгын хорооны хуралдаанд танилцуулахыг тооллогын комисст даалгасугай. ТББХ-ны дарга Ж.Бат-Эрдэнэ гэсэн.

Тогтоолын төсөлтэй холбоотойгоор санал хэлэх гишүүд байна уу. Асуух асуулттай гишүүд байна уу? Алга байна. Тэгвэл тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Энэ чинь бэлдчихсэн байгаа биз дээ.

Санал хураалтад 23 гишүүнээс 17 гишүүн оролцож, 73.9 хувиар тооллогын комисс батлагдлаа.

Тооллогын комисс ажилдаа оръё. Одоо удахгүй биз дээ. Тооллогын комисс хуралдаад даргаа сонгоно. Тэгээд журмаа танилцуулна шүү. Гишүүд байж байгаарай. Одоо ингээд тооллого санал хураалт шууд явна шүү. За Баярбаатар гишүүнд микрофон өгье. Гишүүд суудалдаа сууж байгаарай.

Б.Баярбаатар: Гишүүд суудлаа эзлэхийг хүсье. Санал хураалтаа хурдан зохион байгуулах нь зөв байх гэж бодож байна.

Тооллогын комиссыг Улсын Их Хурлын 3 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан. Батын Батбаатар, Баярмагнайн Баярбаатар, Жудагийн Баярмаа гэсэн бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан. Ингээд хуралдаад Батын Батбаатар гишүүнийг тооллогын комиссын даргаар, миний бие өөрөө нарийн бичгийн даргаар ингээд тус тус сонгосон тогтоолыг баталлаа.

Нууц санал хураалт явуулах, дүн гаргах журмыг та бүхэнд танилцуулъя. Санал хураалтыг дараах журмаар явуулна.

1.Тооллогын комиссын дарга, нарийн бичгийн даргыг сонгоно. Сая сонгосон тогтоолоо та бүхэнд танилцуулсан. Санал хураах хуудасны загварыг батална. Саналын хуудас бүрд тэмдэг дарж баталгаажуулна. Санал хураах хайрцгийг Байнгын хорооны гишүүдэд үзүүлнэ. Санал хураах хайрцгийг хааж битүүмжилнэ. Санал хураалтад оролцох Байнгын хорооны гишүүдийн нэрсийг цагаан толгойн үсгийн дарааллаар дуудна. Байнгын хорооны гишүүдэд саналын хуудас өгнө. Саналын хуудас авсан гишүүнээр гарын үсэг зуруулж жагсаалтаа тэмдэглэнэ. Гишүүд тусгайлан зассан ширээн дээрх үзгээр саналаа дугуйлна. Гишүүд зөвшөөрсөн эсвэл татгалзсан саналын аль нэгнийх нь өмнөх дугаарыг дугуйлна. Саналын хуудас тараалтад хяналт тавина. Санал хураалт дууссаныг мэдэгдэж, лац хөдөлгөөгүй байгааг гишүүдэд харуулж хайрцгийг нээнэ. Саналын хуудсыг тооллогын комиссын гишүүд Байнгын хорооны гишүүдэд харагдах газарт тоолно. Саналын хуудсыг нэг бүрчлэн шалгана. Хүчинтэй, хүчингүй хуудасны тоог гаргана. Дараах тохиолдолд саналын хуудсыг хүчингүйд тооцно.

1.Илүү тэмдэглэл хийсэн буюу хаалтанд одоо хоёуланг нь дугуйлсан. Ямар ч тэмдэглэгээ хийгээгүй буюу санал өгөөгүй. Санал хураалтын дүнг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн тоо болон хувиар нь гаргана. Санал хураалтын дүнг комиссын тогтоолд тусгана. Санал хураалтын дүнг Байнгын хорооны хуралдаанд танилцуулна.

2.Санал хураалтын бичиг баримт бичгийг хүлээлгэж өгнө өө гэсэн ийм журам байна.

Саналын хуудсан дээр та зөвшөөрсөн саналынхаа өмнөх дугаарыг дугуйлан саналаа илэрхийлнэ үү гэсэн бичиг байна.

Монгол Улсын Ерөнхий сайдад итгэл хүлээлгэх тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг гээд доор нь 1.Зөвшөөрсөн. 2.Татгалзсан гэсэн ийм 2 хувилбар байж байгаа. Эндээс саналаа өгнө.

Дараа нь Байнгын хорооны тогтоолыг би та бүхэнд уншиж танилцуулъя. Нууц санал хураалт явуулах, дүн гаргах журам батлах тухай гэсэн тогтоолын төсөл. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.6 дахь хэсгийг үндэслэн Улсын Их Хурлын ТББХ-ноос Тогтоох нь.

Монгол Улсын Ерөнхий сайдад итгэл хүлээлгэх тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар ТББХ-ны хуралдаанд Нууц санал хураалт явуулах, дүн гаргах журмыг 1 дүгээр, саналын хуудасны загварыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай гэсэн ийм тогтоолын төсөл байна аа. тогтоолын төслийг баталж өгнө үү.

Ж.Бат-Эрдэнэ: Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10.6-д заасны дагуу санал хураалтыг санал хураах хуудсаар явуулах бол гишүүдээс бүрдсэн тооллогын комисс байгуулна. Нууц санал хураалт явуулах дүнг гаргах журмыг тооллогын комисс байгуулж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар батална гэсэн байгаа шүү.

Ингээд тооллогын комисс журмаа оруулж ирлээ. Нууц санал хураалт явуулах дүнг гаргах журам батлах тухай. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 16 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлын ТББХ-ноос Тогтоох нь.

Монгол Улсын Ерөнхий сайдад итгэл хүлээлгэх тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар ТББХ-ны хуралдаанд Нууц санал хураалт явуулах, дүнг гаргах журмыг 1 дүгээр, саналын хуудасны загварыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай. ТББХ-ны дарга Ж.Бат-Эрдэнэ гэсэн.

За Байнгын хорооны тогтоолтой холбоотойгоор асуух асуулт, асуух үг хэлэх гишүүд байна уу? Алга байна. Тэгвэл тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна биз дээ. Санал хураалт. Энэ чинь батална биз дээ. Баталж байж явна шүү дээ энэ чинь хэд юу яасан. За санал хураалтад бэлдье. Гишүүд орцгоосон уу. Санал нууц санал хураалт явуулах, дүн гаргах журам батлах тухай Байнгын хорооны тогтоолын төслийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

Санал хураалтад 23 гишүүнээс 17 гишүүн оролцож 73.9 хувиар санал дэмжиж, тогтоол батлагдлаа.

Тооллогын комисс ажилдаа оръё. Баярбаатар гишүүн микрофон дээр ярих уу? Баярбаатар гишүүний микрофоныг өгье.

Б.Баярбаатар: За гишүүдийг цагаан толгойн нэрсийн дарааллаар дуудна. Нэрсээ нэрс дуудсан гишүүд Баярмаа гишүүн дээр ирээд, саналын хуудсаа аваад бүртгүүлээд саналын хуудсаа аваад энэ индэр дээр очиж саналаа өгөөд, саналын хайрцаг руугаа саналын хуудсыг нэг нугалж хийнэ шүү. Ганцхан нугалж л хийнэ. Хоёр, гурав нугалж ингэж хувилж бол хийхгүй гэдгээ анхааруулъя.

Улсын Их Хурлын гишүүн О.Алтангэрэл Баярмаа гишүүнээс юугаа аваад, май энэ дээр. Бал нь тэнд байгаа. Саналын балаар. За Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан, за Шадар сайд Улсын Их Хурлын гишүүн С.Амарсайхан. Амарсайхан сайд байна уу? Тэгнэ, зөвшөөрнө. Амарсайхан сайд энд гарын үсгээ зураад тэгээд Баярмаа гишүүнээс саналын хуудас авна шүү. Саналын хуудасны юу санал өгөх томъёоллынхоо өмнөх дугаарыг дугуйлна шүү. Байнгын хорооны дарга Бат-Эрдэнэ. Ж.Бат-Эрдэнэ. Тийм тоог нь дугуйлна шүү. Энэ дээр гарын үсэг зурчих. Улсын Их Хурлын гишүүн Болормаа. За журмын 10-т гишүүд зөвшөөрсөн, эсвэл татгалзсан гэсэн саналын аль нэгийг нь өгөхдөө өмнөх дугаарыг дугуйлна аа. Улсын Их Хурлын гишүүн Батлан хамгаалахын сайд С.Бямбацогт, Улсын Их Хурлын гишүүн АН-ын дарга Л.Гантөмөр, Улсын Их Хурлын гишүүн Хүн намын дарга Доржханд сайд байна уу? Доржханд сайдыг дуудаарай манай Байнгын хорооны ажлын алба.

Улсын Их Хурлын гишүүн Зулпхар, Улсын Их Хурлын гишүүн МАН-ын бүлгийн дарга Мөнхбаатар дарга энд зураадах гарын үсэг зураадах. Улсын Их Хурлын гишүүн Номинчимэг, Улсын Их Хурлын гишүүн Үндэсний эвслийн дарга Номтойбаяр, Доржханд сайд та наашаа хүрээд ир, хүрээд ир. Гарын үсгээ зураад өгчих. Улсын Их Хурлын гишүүн Одбаяр таныг урьж байна. Одбаяр таныг урьж байна. Улсын Их Хурлын дэд дарга Пүрэвдорж таныг урьж байна. Улсын Их Хурлын гишүүн Сандаг-Очир, Улсын Их Хурлын гишүүн Туваан таныг урьж байна. Туваан сайд байна уу? Улсын Их Хурлын гишүүн Учрал таныг урьж байна. Уянга гишүүн байхгүй байгаа юм байна тиймээ. Улсын Их Хурлын дэд дарга Цогтгэрэл бүлгийн дарга АН-ын бүлгийн дарга Цогтгэрэл, Улсын Их Хурлын гишүүн Шижир, Улсын Их Хурлын гишүүн Л.Энх-Амгалан, Улсын Их Хурлын гишүүн Батын Батбаатар, Улсын Их Хурлын гишүүн Жудагийн Баярмаа. Ингээд хамгийн сүүлд миний бие өөрөө ийшээ явчихъя.

Ж.Бат-Эрдэнэ: Баярбаатар гишүүний микрофоныг өгье.

Б.Баярбаатар: Тооллогын комиссын тогтоол танилцуулна. Та бүхэнд санал хураалтын дүнгийн тухай. Тооллогын комиссоос Тогтоох нь.

1.Монгол Улсын Ерөнхий сайдад итгэл хүлээлгэх тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг ТББХ-ны хуралдаанаар хэлэлцээд Монгол Улсын Ерөнхий сайдад итгэл хүлээлгэх тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг дэмжих эсэх асуудлаар нууц санал хураалт явуулав.

2.Байнгын хорооны хуралдаанд нийт 23 гишүүн байснаас нууц санал хураалтад 23 гишүүн оролцов.

Санал хураах хайрцгийг нээхэд Монгол Улсын Ерөнхий сайдад итгэл хүлээлгэх тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг дэмжих эсэх асуудлаар 23 ширхэг саналын хуудас гарсан ба хүчинтэй саналын хуудас 23, хүчингүй саналын хуудас 0 байлаа.

Монгол Улсын Ерөнхий сайдад итгэл хүлээлгэх тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг зөвшөөрсөн, татгалзсан гэсэн санал тус тус бүрээр нэг бүрчлэн тоолж гаргахад,

1.Зөвшөөрсөн гэсэн саналыг дугуйлсан саналын хуудас 17 ширхэг буюу 73.9 хувь.

2.Татгалзсан гэсэн саналыг дугуйлсан саналын хуудас 6 ширхэг буюу санал хураалтад оролцсон нийт гишүүдийн 26.1 хувь байна аа.

Тооллогын комиссын дарга Б.Батбаатар, Ж.Баярмаа, Б.Баярбаатар гэсэн ийм тогтоолын төслийг хүлээлгэж өгье өө.

Ж.Бат-Эрдэнэ: Тогтоолын төсөлтэй холбоотойгоор асуулт, санал байхгүй. Санал хураалтыг сая Баярбаатар дарга танилцуулчихлаа тийм үү. Санал хураалтын дүнг танилцлаа.

Монгол Улсын Ерөнхий сайдад итгэл хүлээлгэх тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэн шийдвэрлэлээ.

Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ танилцуулна аа.

Ингээд өнөөдрийн Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууслаа.

11.37 цагт

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА